



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **Монгол Улсын Боловсролын их сургууль,
Нийгэм хүмүүнлэгийн ухааны сургууль**

Хөтөлбөрийн нэр: **Багш, гадаад хэлний боловсрол**
(Орос, Хятад, Солонгос, Япон хэл)

Индекс: **D011409**

Шинжээчийн баг:

Ахлагч: Т.Төрбат Хэл шинжлэлийн ухааны доктор, профессор

Гишүүд: Г.Томтогтох Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
тэргүүлэх профессор

Д.Ундрах Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны
сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд
профессор

Н.Мэнд Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн
Гадаад хэлний сургуулийн Эрдэмтэн нарийн
бичгийн дарга

Ц.Дэлгэрэхцэцэг Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны
сургуулийн Ази судлалын тэнхимийн дэд
профессор

Он сар өдөр: 2020-05-28

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

БМИУЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
 МУБИС – Монгол улсын боловсролын их сургууль
 НХУС – Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль
 ОХАЗТ- Орос хэл, арга зүйн тэнхим
 ӨYT – Багш, гадаад хэлний боловсрол, бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
 PLO – хөтөлбөрийн суралцахуйн үр дүн
 CLO – хичээлийн суралцахуйн үр дүн
 ЕБС – ерөнхий боловсролын сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол улсын Боловсролын их сургууль (МУБИС) The Mongolian National University of Education (MNUE)	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, гадаад хэлний боловсрол (Teacher, foreign language)	
Индекс	D011409	
Шинжээчид	Ахлагч: Т.Төрбат Гишүүд: Г.Томтогтох Д.Ундрах Н.Мэнд Ц.Дэлгэрэхцэцэг	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Н.Түмэнжаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2020-05-21 Пүрэв гараг	Шинжээчийн багийг танилцуулна. /Мэргэжилтэн/
		Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн ажлын албаны захирал О.Янжмаа үг хэлж, шинжээчийн багийг сургуульд хүлээлгэн өгнө.
		Шинжээчийн багийн ахлагч магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна.
		Сургуулийн захирал үг хэлнэ . Хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойших мэдээллийг оруулах/
		Сургуулийн орчинтой танилцах
		Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах

	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
2020-05-22 Баасан гараг	Багш нартай уулзах
	Оюутнуудтай уулзах
	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах
	Ажил олгогчдын төлөөлөлтэй уулзах
	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-өөс эрхлэн мөрдүүлж буй Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд мөрдөх заавар, журмууд, БСШУ-ны Сайдын 2016 оны 02 сарын 19-ний өдрийн А/53 тушаал, Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайлан, Шинжээчийн үнэлгээний тайлан, холбогдох бусад заавар, эрхийн баримт бичиг, БМИҮЗ-ийн Ажлын албаны захирлын 2020 оны 02 сарын 06-ний өдрийн 4/28 тушаал.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

МУБИС – Монгол улсын боловсролын их сургууль нь орос хэлний багш бэлтгэх хөтөлбөрийг 1952 оноос, хятад хэлээр 1993 оноос, солонгос хэлээр 2000 оноос, япон хэлээр 2007 оноос тус тус мэргэжлийн багш бэлтгэж эхэлсэн байна. Энэ хугацаанд дөрвөн хэлээр нийт 3965 багш бэлтгэсэн байна.

МУБИС-ийн (1951 онд Багшийн Институт байгуулагдсан) удирдлага, хамт олон тус их сургуулийн **Алсын харааг**: Багш боловсролын чанараар Ази тивд өрсөлдөхүйц их сургууль байх,

Эрхэм зорилгыг: Хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч багш, боловсролын болон шинжлэх ухааны бусад салбарын мэргэжилтэн бэлтгэн гаргах,

Зорилгыг: Эрдэм шинжилгээ, инноваци, сургалтын арга зүй, технологийг хөгжүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг орчин үеийн их сургуулийн түвшинд хүргэх, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог бүрдүүлнэ,

Уриаг: Манлайлагч, судлаач багш-хөгжлийн түлхүүр хэмээн тус тус тодорхойлон ажиллаж байна.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг Багш, гадаад хэл мэргэжлээр шинжлүүлж буй Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль 2019-2020 оны хичээлийн жилд D011409 индекстэй Багш, гадаад хэлний боловсролын бакалавр (Орос, Хятад, Солонгос, Япон) буюу дөрвөн хэлний багш бэлтгэх хөтөлбөр тус бүрээр

Өөрийн үнэлгээний тайланг гарган ирүүлсэн дагуу шинжээчийн баг ажиллаж БМИҮЗ-ийн холбогдох заавар, журмын дагуу хөтөлбөрийн магадлан шинжилгээг 2020 оны 5-р сард хийлээ.

Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль нь 2019-2020 оны хичээлийн жилд 130 гаруй багштай. Үүнээс: 56 доктор, 11 профессор, 21 дэд профессор, 1 ардын багш ажиллаж бакалаврын түвшинд 3309, магистрантурын 460 гаруй, докторантурын 224 оюутан, нийт 4001 суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна.

Өөрийн үнэлгээний тайланг гарган ирүүлсэн “Багш, гадаад хэлний боловсрол” багц хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад багш бэлтгэх сургалтын агуулга, аргагүйг нийгмийн хөгжлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх, сургалт, эрдэм шинжилгээний орчин нөхцөлийг сайжруулах, профессор багш нарын мэргэжлийн ур чадвар, судалгааны чадамжийг дээшлүүлэх, багш ажилчдын нийгмийн асуудлыг үе шаттай шийдвэрлэх үүрэг зорилтоо амжилттай хэрэгжүүлэх талаар сургуулийн захиргаа, тэнхимүүд нэмэлт хөшүүрэг болгон хамт олны идэвх зүтгэлийг өрнүүлэн ажилласан байна.

Тус сургуулийн хамт олон эдийн засаг, нийгмийн эрчимтэй хөгжлийн шинэ орчинд сургуулийнхаа хөгжлийн хэтийн болон ойрын бодлого зорилтыг тодорхойлж, багш боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх талаар багагүй зүйлийг санаачлан хийж, тодорхой ахиц дэвшилд хүрсэн нь шинжлүүлж буй хөтөлбөрүүдийн өөрийн үнэлгээний тайланд тусгалаа олсон байна. Үүнд, сургалт, судалгааны материаллаг орчин, бүтээлч үйлийн орчин, менежментийн тогтолцоо, хүний хүчин зүйл, сургалтын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөр, аргагүй, хэрэглэгдэхүүн зэргийг шинэчлэн сайжруулж, чанартай мэргэжилтэн бэлтгэх үүрэг зорилтод хамт олноо чиглүүлэн төлөвлөсөн ажлуудаа амжилттай хэрэгжүүлж иржээ. Олон улсын жишиг, хөгжлийн хандлагад нийцүүлэн сургалтын цахим орчин бүрдүүлж, сургалт, эрдэм шинжилгээ, удирдлага мэдээллийн 10 орчим системийг нэвтрүүлснээр тэдгээрийн үйл ажиллагаа нь тогтмолжсон, багш, оюутны өдөр тутмын амьдралд хэрэгжиж хэвшсэн байна.

Хөтөлбөрийн ӨҮТ-г магадлан шинжлүүлж буй дөрвөн гадаад хэлээр ОХУ-ын Халимагийн улсын их сургууль, Уралийн Холбоотын их сургууль, Эрхүүгийн улсын их сургууль, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Их сургууль, Багшийн их сургууль, Япон улсын Азийн их сургууль, Хёого мужийн боловсролын их сургууль, БНХАУ-ын Зүүн хойдын багшийн их сургууль, БНСУ-ын Боловсролын их сургууль зэрэг гадаадын 10 гаруй сургууль, Хятад хэлийг түгээн дэлгэрүүлэх алба, Тайван сан, Япон сан, JICA, KOICA зэрэг гадаадын байгууллагатай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж иржээ. Үүний зэрэгцээ БНСУ, Япон, БНХАУ зэрэг 10 гаруй улс орноос МУБИС-д 120 гаруй суралцагчийг бакалавр, магистр, докторын түвшинд хүлээн авч сургалтад хамруулж байгаа үйл ажиллагаанд магадлан шинжлүүлж буй гадаад хэлний дөрвөн хөтөлбөрийн багш нарын идэвх зүтгэл гарган ажилаж буйг тэмдэглэх нь зүйтэй юм.

Магадлан шинжлүүлж буй дөрвөн багц хөтөлбөрийн онцлогийг:

- Үр дүнд суурилсан шаталсан загвараар боловсруулсан.
- Үр дүнг мэдлэг, чадвар хандлагаар нь 3 чиглэлд залгамж холбоо, хэрэгжиж хэмжигдэхүйц болгосон.
- Үнэт зүйлд суурилсан,
- Суралцагчдын хувьд хүнлэг зарчимд тулгуурлаж чөлөөт сонголтын зарчимтайгаар боловсруулсан /хичээл, багш, хуваарь сонголтын/ хэмээн ӨҮТ-д тус тус тодорхойлсон байна.

Цаашид:

- Хөтөлбөрийг орчин цагийн хандлагаар байнга сайжруулан хөгжүүлэх,
 - Оролцогч талуудын саналыг тусгах,
 - Сургалтын чанар, үр дүнгийн ахицад анхаарах,
- Суралцагчдын бие даан суралцах, хөгжих боломжийг бүрэн хангахад байнга анхаарах,
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ тогтмол хийхэд тус тус анхаарах талаар нийт ӨҮТ-д тусгасан нь зүйтэй байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

Солонгос хэлний багш мэргэжлийн монгол дахь зах зээлийн эрэлт нь ЕБС-иудад солонгос хэлний анги нээгдэж байгаа, солонгос хэлний ангийн төгсөгчид төрийн болон төрийн бус байгууллагуудад ажиллаж хөрвөх бололцоо их, 2005 оноос эхлэн Солонгос улсад ажиллах хүчин илгээх болсон зэргээр тодорхойлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан өөрөө асуудал шийдвэрлэх боломж бүхий дадлагыг гол болгож боловсруулсан.

Хятад:

- 2015 оны “Сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын удирдамж”-ийн дагуу хятад хэлний багш мэргэжлийн сургалтын төлөвлөгөөн дэх бүх хичээлийн стандартыг шинээр боловсруулж, төлөвлөгөөг шинэчлэн, сургалтын төлөвлөгөөнд орсон 40 хичээлийн хөтөлбөрийг дахин боловсруулсан.
- Багш, хятад хэлний боловсрол хөтөлбөрийг сайжруулах зорилгоор дотоодын ижил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулахдаа орчуулагч, багш бэлтгэдэг ХУИС-н сургалтын төлөвлөгөөтэй харьцуулж үзэхэд хөтөлбөрийн багтаамжийн хувьд :
МУБИС -ийн “Багш, хятад хэлний боловсрол”-ын хөтөлбөр нь ХУИС -ийн орчуулагч, багш бэлтгэх хөтөлбөрөөс 4 кредитээр илүү байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХУИС /6-р тал/ Багшлах дадлага 8 кредитээр судалдаг, МУБИС Танилцах дадлага-1кр, Судлах дадлага-2кр, Туршин заах дадлага-5кр, Багшлах дадлага-5кр нийт 13 кр судалдаг нь манай сургуулийн багш мэргэжилтэн бэлтгэдэг хөтөлбөрийн нэг онцлог тал болж байна.
- Мөн шинэчлэн сайжруулсан хөтөлбөрт сайн дурын ажил 2 кр судалдаг байхаар тусгаж өгсөн нь оюутан хүмүүнлэгийн сайн дурын ажилд биечлэн оролцож нийгэм, хамт олны дунд орж ажиллах, багаар ажиллаж сурахад чухал ач холбогдолтой юм.

Япон:

- 1990 оноос хойш Монгол Япон улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт идэвхтэй өрнөж байгаа тул хоёр улсыг холбох япон хэлтэй боловсон хүчинг бэлтгэх эрэлт хэрэгцээ нэмэгдсээр ирсэн. Улмаар 2018 оноос хойш Япон улс нь ажиллах хүчний хомсдолд орсонтой холбоотойгоор гадаадаас япон хэлтэй дадлагажигч авах бодлогыг хэрэгжүүлж байгаа. Иймд япон хэлний багшийн эрэлт хэрэгцээ дотоодод улам нэмэгдэж буй. Монгол улсын боловсролын байгууллагуудад ажиллаж байгаа 250 багшийн 20 хувь нь МУБИС-ийн төгсөгч байгаа гэсэн судалгааны дүн гарчээ. Тухайн

мэргэжлээр жил бүр тодорхой тооны элсэгч элсэж байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээ байгааг харуулж байгаагийн дээр төгсөгчид зөвхөн багшийн ажилд орох биш, өөр ажлын байранд тэнцэн ажиллаж байгаа нь энэ хөтөлбөрийн төгсөгчийн хөрвөх чадвар өндөр байгааг нотолж байна гэж үзжээ. Түүнчлэн Япон сангийн судалгаагаар Монгол дахь япон хэлний боловсролын байгууллага, суралцагчийн тоо нэмэгдэж байгаа нь цаашид багшлах боловсон хүчний эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна.

- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар дэлхийн япон хэлний боловсролын өөрчлөлт шинэчлэл, тэр дундаа япон хэлний боловсролын JF стандартын үзэл баримтлалыг өөрийн сургалтын бодлогод тусгаж ажиллаж байгаа, мөн Монголын япон хэлний багш нарын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буйгаа тайланд дурджээ.
- Хөтөлбөрийн харьцуулсан судалгааг ХИС-ийн “гадаад хэлний боловсрол, япон хэл”, Хятадын ДДХИС-ийн япон хэлний бакалаврын хөтөлбөртэй харьцуулж, өөрийн онцлог, давуу талд дүн шинжилгээ хийсэн байна. Цаашид гадаад дотоодын илүү олон хөтөлбөртэй харьцуулж, зөвхөн хичээлийн нэр төрлийн түвшинд бус, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө улам сайжруулах тал дээр судалгаа хийх шаардлагатай

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон хэлний багшийн эрэлт хэрэгцээ дотоодын зах зээл дээр улам нэмэгдэж байгаа, багш мэргэжлээр зөвхөн МУБИС сургалт явуулдаг зэрэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд давуу тал нь болж байна.
- Монгол улсын боловсролын байгууллагуудад ажиллаж байгаа 250 багшийн 20 хувь нь МУБИС-ийн төгсөгч байна.
- Тухайн мэргэжлээр жил бүр тодорхой тооны элсэгч элсэж байгаа нь зах зээлийн эрэлт хэрэгцээ байгааг харуулж байгаагийн дээр төгсөгчид зөвхөн багшийн ажилд орох биш, өөр ажлын байранд тэнцэн ажиллаж байгаа нь энэ хөтөлбөрийн төгсөгчийн хөрвөх чадвар өндөр байгааг нотолж байна.
- Хөтөлбөрийн харьцуулсан судалгааг ХИС-ийн “гадаад хэлний боловсрол, япон хэл”, Хятадын ДДХИС-ийн япон хэлний бакалаврын хөтөлбөртэй харьцуулж, өөрийн онцлог, давуу талд дүн шинжилгээ хийсэн байна. Цаашид гадаад дотоодын илүү олон хөтөлбөртэй харьцуулж, зөвхөн хичээлийн нэр төрлийн түвшинд бус, хичээлийн хөтөлбөрийн агуулгыг харьцуулсны үндсэн дээр сургалтын хөтөлбөрөө улам сайжруулах тал дээр судалгаа хийх шаардлагатай.

Анхаарах асуудал:

- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар дэлхийн япон хэлний боловсролын өөрчлөлт шинэчлэл, тэр дундаа япон хэлний боловсролын JF стандартын үзэл баримтлалыг өөрийн сургалтын бодлогод тусгаж ажиллаж байгаа, мөн Монголын япон хэлний багш нарын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буйгаа тайланд дурджээ. Гэвч хичээлийн стандарт, хөтөлбөр зэрэгт япон хэлний стандартыг бодитой тусгасан байдал ажиглагдахгүй байна.

Зөвлөмж:

- Япон хэлний боловсролын JF стандартын үзэл баримтлалыг хичээлийн стандарт, хөтөлбөр, улмаар хичээлийн агуулгад тусгаж ажиллах хэрэгтэй. Тухайлбал, сургалтын зорилтот түвшинг тодорхойлох, хичээлийн зорилгыг тодорхойлох, үнэлгээний хэмжүүрийг тогтоох, өөрийн үнэлгээг нэвтрүүлэх гэх мэтээр тусгаж ажиллавал зохимжтой.

Орос:

- Орос хэлний хичээлийг ЕБС-ийн дунд ангид заавал, ахлах ангид сонгон суралцах хэлбэрээр заах болсон;
- ОХУ-ын Засгийн газрын тэтгэлгээр жил бүр 500-аас дээш оюутан элсэх боломжтой болсноор орос хэл судлах суралцагчдын тоо нэмэгдсэн;
- 1952 оноос орос хэлний багш бэлтгэж ирсэн туршлага;
- Орос хэлний багш мэргэжлээр төгссөн төгсөгч өөр салбарт хөрвөж ажиллах боломж их байгаа нь тухайн хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай болохыг нотолж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Орос хэлний багш бэлтгэж ирсэн 68 жилийн туршлага;
- Одоогийн байдлаар орос хэлний багш тууштай бэлтгэж байгаа өрсөлдөгч МУИС-иас өөр байхгүй.

Анхаарах асуудал:

- Орос хэлний багш мэргэжилтэй төгсөгч хөрвөх чадвартай гэдэгт баримжаалж мэргэжил сурталчлах, элсэлт авах нь төдийлөн сайн хувилбар биш.
- Ажил олгогчид, тухайлбар ярилцлагад оролцсон ажил олгогчдын 50 гаруй хувь нь орос хэлний хичээл заалгахад “Орос хэлний багш” хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид хос хэлээр /орос, англи, орос, монгол гэх мэт/ төгссөн

төгсөгчдөөс илүү байгааг анхааран, Орос хэлний багш мэргэжлээр төгссөн төгсөгчдийг ажилд авах сонирхолтой байгаагаа илэрхийлж байна

Зөвлөмж:

- Орос хэлний багшийн хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нөхцөл, тууштай өрсөлдөгч байхгүй, олон жилийн туршлагадаа тулгуурлан үйл ажиллагаагаа улам сайжруулах.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар хавсаргаагүй.

Хятад:

- Хөтөлбөрийн зорилгоо сургуулийн эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөний зорилтуудтай уялдуулан тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилго зорилтыг тодорхойлж хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг чадвар болон хөтөлбөрийн зорилго зорилтууд хоорондын уялдаа, холбоог гаргасан.
- Сургалтын төлөвлөгөөнд 3 үе шаттай үнэлгээ хийж 2018 онд шинэчлэн баталсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн боломжит ажлын байрыг тодорхойлсон.
- Төгсөгчидтэй эргэх холбоо сайтай, дахин сургалт явуулдаг.

Анхаарах асуудал:

- Ажил олгогч, төгсөгчдөөс авсан судалгааны асуулт, дүгнэлт байхгүй.

Зөвлөмж:

- Төгсөгчдөөс мөшгөх судалгаа, ажил олгогчдоос судалгаа авч саналыг хөтөлбөртөө тусгах.

Япон:

- “МУБИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө” болон бусад бодлогын бичиг баримтад заасны дагуу хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг “Хүүхэд бүрийг хөгжүүлдэг чадамжтай багш бэлтгэнэ” гэж тодорхойлдог байна.
- “МУБИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө”, “Шинэ зууны багшийн загвар”, “МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал” зэрэг хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичгүүдийг дагаж мөрддөг тухай тайланд өгүүлжээ.
- Хөтөлбөрийн зорилгын дагуу 8 зорилтыг дэвшүүлж ажилладаг ба хөтөлбөрөөр эзэмших суурь мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд болон эзэмших мэдлэг, чадварын хоорондын уялдаа холбоог Course Learning Outcomes загвараар тодорхойлсон нь сайшаалтай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- “МУБИС-ийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө”, “Шинэ зууны багшийн загвар”, “МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал” зэрэг хөтөлбөрийн зорилгын дагуу 8 зорилтыг дэвшүүлж ажилладаг ба хөтөлбөрөөр эзэмших суурь мэдлэг, чадвар, хандлагыг Course Learning Outcomes загвараар тодорхойлсон онцлогтой байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн гадаад хэлний мэдлэгийн түвшинг хэмжих, үнэлэх үйл ажиллагаа системтэй хийгдэж ирээгүй тул төгсөгчдийн мэдлэг чадварын түвшин жигд бус байх хандлагатай.

Зөвлөмж:

- Суралцагчдын япон хэлний түвшин тогтоох шалгалт өгөх үйл ажиллагааг дэмжих, чиглүүлэх, тогтмолжуулах шаардлагатай.

Орос:

- Энэхүү хөтөлбөр нь сургалтын үйл ажиллагааг суралцагч бүрийн хөгжлийн ялгаатай байдал, онцлогт үндэслэн шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах суурь мэдлэг, чадвар эзэмшин, түүнийгээ амьдрал практикт хэрэглэх хүсэл эрмэлзэлтэй, суралцагч болон өөрийгөө байнга хөгжүүлэх сэтгэлгээтэй багш мэргэжилтэн бэлтгэх зорилготой хэрэгжиж байгаа нь мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл /Туршлага:

- Орос хэлний багш боловсролын хөтөлбөрийн зорилго, зорилт Монгол Улсад мөрдөж байгаа холбогдох хууль, дүрэм журмын шаардлагатай бүрэн нийцсэн байна.

Анхаарах асуудал:

- Гадаад хүнд зориулсан орос хэлний сургалт, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэдлэгийн үнэлгээ, жишээ нь ТРКИ зэргийг хөтөлбөрийн зорилго, зорилтод тусгах талаар анхаарах шаардлагатай.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Батлагдсан хөтөлбөр
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Хятад:

- Батлагдсан хөтөлбөр, нэгдсэн төлөвлөгөөг тайланд оруулсан
- Батлагдсан хичээлийн хөтөлбөрийг хавсаргасан
- Хөтөлбөр төлөвлөлтийн баримт бичгийн жагсаалт хийсэн

- Сургалтын төлөвлөгөөний одоогийн бүтцийг БСШУЯ-ны Сайдын А174 тушаалтай харьцуулсан
- МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх бүх хөтөлбөрийн бүтцийг тоочсон.
- Өөрийн үнэлгээний тайланд SWOT, TOWS шинжилгээ хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн шинэчлэлийн талаар олон нийтэд мэдээлсэн тухай баримт материалыг тайланд оруулаагүй.

Япон:

- “Багш, гадаад хэлний боловсрол” хөтөлбөрийг Монгол улсын боловсролын салбарт мөрдөж буй бүхий л хууль, дүрэм журамд нийцүүлэн боловсруулахын зэрэгцээ кредит тогтолцоо, чөлөөт сонголтын зарчим зэргийг харгалзан боловсруулжээ.
- Шат шатны хөтөлбөрийн хороогоор дамжуулж сургалтын төлөвлөлт, хяналт, хөтөлбөртэй холбоотой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг, зохих хурлын тэмдэглэлүүдийг хөтөлж мөрдлөг болгодог.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөг батлан мөрдөж ажилладаг ба жилийн графикт ажлууд тогтсон хугацаандаа хийгддэг.
- Хичээл тус бүрээр хөтөлбөрүүдийг боловсруулж, шат шатны хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлж баталдаг. 2017-2018 онд 918 хичээлийн хөтөлбөрийг тэнхимийн болон салбар хөтөлбөрийн хороодоор хэлэлцүүлсэн байна. 2016 онд хичээлийн агуулга, аргазүйг сайжруулах зорилгоор “100 хичээл аян” явуулж, 88 хичээл оролцон 14 хичээлийг шалгаруулж урамшуулж байсан нь сайн туршлага болжээ. Бүх хичээлийн хөтөлбөрийг цахим сүлжээндээ байршуулан ил тод ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2016 онд хичээлийн агуулга, аргазүйг сайжруулах зорилгоор “100 хичээл аян” явуулж, 88 хичээл оролцон 14 хичээлийг шалгаруулж урамшуулж байсан нь сайн туршлага болжээ.
- Бүх хичээлийн хөтөлбөрийг цахим сүлжээндээ байршуулан ил тод ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хичээл хоорондын уялдааг заасан модлог бүтцийн загварт зарим ойлгомжгүй холбоос байхын зэрэгцээ техник алдаа байсан. Түүнчлэн сургалтын төлөвлөгөөнд байдаг ч хэзээ ч сонгогдож байгаагүй хичээлүүд байгааг анхааруштай.

Зөвлөмж:

- Хичээл хоорондын уялдааг заасан модлог бүтцийн загварт жил бүр хичээл сонголт болон анги бүрдэлтийн байдалтай уялдуулан анализ хийж, засаж сайжруулж явбал зохилтой.

Орос:

- Орос хэлний багш” хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг Монгол улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2015-2025/, Монгол улсын Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар батлагдсан “Баклаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024/, 21-р зууны багшийн бодлого /2014/, Багш бэлтгэх хөтөлбөрийн олон улсын харьцуулсан судалгаа /2014/, Монгол улсын боловсролын их сургуулийн баклаврын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал /2015/, Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого /2018/, 2021 он хүртэлх Дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт, Дээд боловсролын сургалтын байгууллагад бэлтгэх ерөнхий мэргэжлийн чиглэл, индекс, 2018 онд баталсан сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээний журам болон МУБИС-ийн Сургалтын журам, Оюутны журам, сургуулийн дүрэм, Хөгжлийн бодлого, Дотоод журам, Хөтөлбөрийн чанарын үнэлгээний удирдамж, Цахим хичээлд тавих шаардлага, Нэмэлт хөтөлбөр боловсруулах удирдамж, Сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж, Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэх удирдамж, Хичээлийн хөтөлбөр боловсруулах удирдамж, Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт, Хичээлийн үнэлгээний удирдамж, Эрдэм шинжилгээний инновацийн журам, Албан тушаалын зэрэглэл шалгуур, Багшийн хөгжлийн хөтөлбөр-ийн бичиг баримт тулгуурлан боловсруулж холбогдох зөвлөл, хороодоор 2015 оноос тооцон үзэхэд нийт 13 удаа хэлэлцүүлж /тайлан 20-21-р тал/ сайжруулж хөгжүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 68 жилийн туршид тасралтгүй хөгжүүлж ирсэн.

Анхаарах асуудал:

- Элсэгчдийн тоо бага

Солонгос хэл: 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Хятад хэл: 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Япон хэл: 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Орос хэл: 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Удирдлага, мэдээллийн систем ULMS/-ээр дамжуулан суралцагч суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөдөг.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмших цогц чадамж, хөтөлбөрийн суралцахуйн үр дүн /PLO/, хичээлийн суралцахуйн үр дүн /CLO/-ийн тоон хамаарлыг тооцон гаргаж дүгнэлт хийсэн.
- Хичээл хоорондын залгамж холбоо, уялдаа холбоонд анализ хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Орчин үеийн хөгжил, хандлагыг тусгасан заах аргын хичээл оруулах.

Хятад:

- Хичээлийн хөтөлбөрийн кредитийн бүтцийн судалгаа хийсэн.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ хийсэн бөгөөд хичээл хоорондын уялдааг судлагдахуун тус бүрээр нь товчоолон гаргасан бөгөөд энэ хичээлийн залгамж холбоог хангах, хичээлийн агуулгын залгамж холбоог хангах талд анхааран төлөвлөсний үр дүнд мэдлэг, чадварыг цогц байдлаар, системтэй эзэмших боломжийг оюутнуудад бүрдүүлж өгсөн байна.
- Хөтөлбөрийг МУБИС-ийн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн бүтцийн журмын дагуу бичсэн бөгөөд үр дүнд суурилсан хөтөлбөр хэмээн үзэж, сургалтын агуулга, аргазүй, технологи, үнэлгээ орчин нөхцөлийг хөтөлбөрийн үр дүнг бий болгоход чиглүүлж, хөтөлбөрийн стандартыг 2015, 2018 онуудад шинэчлэн боловсруулж, хичээл сургалтандаа ашиглаж байна.
- Сургалтын төлөвлөгөөний хичээл хоорондын холбоосыг харуулсан схем хийсэн.
- Суралцагч системээр дамжуулан суралцагч суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөдөг
- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгааг хийж кредит цагийн задаргааг улирлаар нэгтгэсэн дүнг, суралцах сонголтын боломжийг харуулсан зураглал гаргасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хятадын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрүүд болон МУБИС-тай хамтын ажиллагаатай сургуулиудад урт, богино хугацааны тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдан суралцах боломжтой болсон. Үүнд: хятад хэлний багшийн ангийн оюутнууд БНХАУ-ын Зүүн хойд багшийн их сургуульд 1-2 жилийн хугацаатай суралцаж хос дипломтой төгсөх, хятад хэлний багшийн ангийн оюутнууд ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн ажил мэргэжлийн дээд сургуульд 1-2 жилийн хугацаатай суралцахаас гадна шилдэг оюутнуудаа Хятадын засгийн газрын болон Күнзийн институтын нэрэмжит тэтгэлгээр магистрын сургалтад тодорхойлон суралцуулж байна.

Япон:

- Сургалтын хөтөлбөр нь сургалтын стандарттай, түүнд нийцүүлэн хичээлийн хөтөлбөрийг боловсруулдаг. Хичээлийн залгамж холбоог заах модлог бүтцийн схемтэй. Дээрх бүтцэд тулгуурлан суралцахуйн үр дүн ба хичээлүүдийн уялдаа холбооны матрицийг боловсруулан сургалтын үйл ажиллагаагаа хянадаг байна.
- Удирдлагын мэдээллийн системд хичээлүүдийг дээд боловсролын ерөнхий суурь, багш боловсролын суурь, мэргэжлийн гэсэн түвшингээр нь чөлөөлт сонголтын тогтолцооны дагуу сонгох боломжийг бүрдүүлжээ.
- Сургалтын төлөвлөгөө нь нийт 124 кредит цагийн багтаамжтай, лекц дадлагын хичээлийн зохистой харьцааг баримталсан, хичээлийн агуулга нь харилцан уялдаатай, тухайн чиглэлээр цогц чадамж олгохыг зорьсон агуулгатай тул орчин үеийн чиг хандлагад нийцсэн байна. 2014 оноос хойш 32 хичээлийн хөтөлбөрийг бүрэн шинэчилж сургалтандаа мөрдөж байгаа. Сургалтын хөтөлбөрт хувь хүний 12, багш боловсролын 28, академик 16 мэдлэг чадварыг эзэмшүүлэхээр тусган, эдгээрийг хичээлийн хөтөлбөрүүдтэйгээ уялдуулжээ. Түүнчлэн 120+30 кредит давхар хөтөлбөрөөр суралцах боломжийг ч олгож байна.
- Дадлага хийх байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хийж, оюутнуудад дадлагын удирдамж өгөхийн зэрэгцээ хийсэн ажлын дагуу тайлан бичүүлж, түүндээ дүн шинжилгээ хийж ажилладаг байна.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан модлог бүтцийн графикийн дагуу хичээлийг давхардалгүйгээр сонгох боломжийг бүрдүүлжээ. 1,2 ангид дээд боловсролын суурь, 3,4 ангид мэргэшүүлэх хичээлийг сонгон судлахаар төлөвлөж тохируулсан байна.
- Суралцагчийн цагийн ачаалаллыг жигд байлгахын тулд хичээлийн судлах улирлыг оноож тохируулсан байна. Долоо хоногийн дундаж ачаалал нь 23 цаг, бие даалт 21.6 цаг байгаа нь зохистой хэмжээ байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөө нь лекц дадлагын хичээлийн зохистой харьцааг баримталсан, хичээлийн агуулга нь харилцан уялдаатай, тухайн чиглэлээр цогц чадамж олгохыг зорьсон агуулгатай тул орчин үеийн чиг хандлагад нийцсэн байна.
- Багшлах дадлагыг үе шаттай, сайн зохион байгуулалттай хийж ирсэн нь зохих үр дүнгээ өгдөг болох нь суралцагч, төгсөгчидтэй хийсэн ярилцлагаас ажиглагдсан.

Анхаарах асуудал:

- Багш нарт зориулсан сургалтын аргагүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмжийн ном, товхимол хомс.
- Суралцагчид зориулж гаргасан сурах арга барилын талаарх гарын авлага нь шинжлэх ухааны үндэслэлтэй зохиогдоогүй тул учир дутагдалтай.

Зөвлөмж:

- Гадаад хэлний боловсрол, гадаад хэл заах аргын орчин үеийн арга зүйн талаарх ном, товхимол, зөвлөмжийг багш нарт зориулж боловсруулж гаргах.

Орос:

- Орос хэлний багш мэргэжлээр суралцагчдын судалж буй сургалтын төлөвлөгөөний 20,2% ерөнхий суурь хичээл, 14,5% багш боловсролын суурь хичээл 63,3% мэргэжлийн хичээл эзэлж байгаа нь сургалтын агуулга хөтөлбөрийн суралцахуйн үр дүн /PLO/-г хангах боломж олгож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Багшлах дадлагын түвшин сайн. Дадлагын 20 түшиц сургуультай, үйл ажиллагаа тогтмолжсон.

Зөвлөмж:

- Бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын үйл ажиллагааг сайжруулах.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- 2019 оноос мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх сургалтад хамрагдаж ирсэн.
- Үр дүнд суурилсан сургалтыг хэрэгжүүлэхийн тулд сургалтад хэрэглэж буй сургалтын арга, хэлбэрүүдийг тайланд тусгасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Хятад:

- Тодорхой нэг хичээлээр суралцахуйн үр дүнгүүд тэдгээрт хүргэх сургалтын аргазүйг өндөр түвшинд тодорхойлсон байна.
- Сургалтын STEAM нэвтрүүлэн ажиллахдаа сургалтын хандлагыг өөрчлөх тал дээр анхаарч улмаар багш бүр өөрсдийн заадаг хичээл дээр үнэлгээний сан бүрдүүлэн ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарыг сургалт аргазүйн сургалтад байнга суулгаж, хөтөлбөрөө шинэчлэхэд нь бэлддэг.

Япон:

- Оюутан төвтэй, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн, оюутан бүрийн идэвх оролцоог хангахад чиглэсэн, харилцаанд тулгуурласан сургалтын арга зүйг голлодог тухайгаа тайландаа бичсэн байна. Оюутны бие даан асуудал шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэхийн тулд STEAM аргазүйг нэвтрүүлэн ажиллаж байгаа. Оюутны бие даалтад зориулсан цагийг удирддаг багш нарын ажлыг үнэлгээтэй болгосон нь багш, оюутны хамтын ажиллагаа үр дүнтэй болоход эерэгээр нөлөөлж байна. Үр дүнд суурилсан аргазүйг чухалчилдаг нь сургалтын орчин үеийн аргазүйн хандлагыг баримталж байгаагийн нэгэн илрэл болно.
- Сургалтын шинэлэг аргазүйн судалгааг хийж сургалтандаа нэвтрүүлэхийн зэрэгцээ сургалтын технологио хэрхэн сайжруулж байгаадаа дүн шинжилгээ хийдэг болохоо дурьджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан төвтэй, бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн, оюутан бүрийн идэвх оролцоог хангахад чиглэсэн, харилцаанд тулгуурласан сургалтын арга зүйг ашигладаг нэг жишээ нь бичих дадлын хичээл дээр хамтран суралцахуйн аргыг ашиглаж ирснээс харагдаж байна.

Анхаарах асуудал:

- Суралцагч төвтэй арга зүйг бүх хичээл дээр ашиглаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Суралцагч төвтэй арга зүйг үе шаттайгаар бүх хичээл дээр нэвтрүүлж ажиллах тал дээр анхаарах, багш нар хоорондоо туршлага солилцох, багаар ажиллахыг зөвлөж байна.

Орос:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаанд суурилсан арга зүй, чадварт суурилсан арга зүй, хэл сурах, сургах коммуникатив арга зүй, нийгэм соёлын хандлага төлөвшүүлэх арга зүй, хамтран суралцахуйн арга зүй, суралцагч төвтэй сургалтын арга зүй, гадаад хэл сурах, сургах арга барилд сургах арга зүй, идэвхтэй оролцооны арга зүй, даалгаварт суурилсан арга зүй, мэдээллийн технологт суурилсан арга зүйг цогцоор хэрэглэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Гадаад хэлний сургалтад чухал байр эзлэх нийгэм соёлын хандлага төлөвшүүлэх арга зүй сургалтад чухал байр эзэлж байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- Гадаад хэлний хичээлийн орчуулгагүй сургалтын аргыг зарим хичээлээр турших.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- “Сургалтын үнэлгээний удирдамж ба үнэлгээний шалгуур үзүүлэлт, “төгсөлтийн үнэлгээний удирдамж”-ийн дагуу оюутны үнэлгээг хийдэг.
- Явцын болон эцсийн үнэлгээ хийдэг.
- Гадаад чанарын хяналт хийхийн тулд гарааны ба ахицын үнэлгээ хийдэг.
- Үнэлгээний санг тогтмол сайжруулдаг.

- 2017 оноос хойш үнэлгээний талаарх сургалтад тогтмол хамрагдаж ирсэн.
- Удирдлага мэдээллийн систем /ULMS/-ээр дамжуулан багшийн үнэлгээний нормаль тархалт, оюутны голч дүнгийн анализ хийж оюутан тухайн хичээлээр ямар эрэмбэд байгааг харуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагчийн хэлэхүйн ур чадварын ахиц, хөгжлийг ТОPIK зэрэг албан ёсны хөндлөнгийн үнэлгээгээр үнэлдэг байх.

Хятад:

- Блум таксоном буюу танин мэдэхүйн шаталсан шатлалаар оюутны мэдлэг, хэрхэн ахиж дэвшиж буйг хэрхэн үнэлдэг талаар тодорхой тусгасан.
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/ хийсэн.
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журамтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын үнэлгээний бодит байдлын шинжилгээг хийсэн (ULMS)
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлтийг нарийн дэлгэрэнгүй хийсэн.

Анхаарах асуудал:

- Оюутны дүнгийн талаар сургалтын албаны гаргадаг статистик чанарын болон тоон үзүүлэлтэд хийсэн анализыг дараа жилийн ажилд хэрхэн яаж тусгадаг гэдэг нь тодорхойгүй байна.

Япон:

- Үнэлгээний олон төрлийн аргазүйг ашигладаг, тэр дундаа Блумийн таксоном, рубрик арга, сорил, цахим сорил, гүйцэтгэлд суурилсан ур чадварын үнэлгээ г.м.

- Хичээл бүрийн онцлогт тохирсон үнэлгээний төрөл, хэлбэрийг сонгон хэрэглэдэг байна. Оюутнуудын дүнгийн нормал тархалтын шинжилгээг сургуулийн хэмжээнд програмаар хийдэг байна.
- “МУБИС-йн сургалтын журам”-д заасны дагуу явцын болон төгсөлтийн шалгалтын журмаа даган ажилладаг. Оюутнуудад хичээлийн жилийн эхэнд үнэлгээний аргачлалыг танилцуулж, ил тод, ижил тэгш байх зарчмыг баримталдаг.
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалтыг сургуулийн болон хөтөлбөрийн хэмжээнд хийж, дүн шинжилгээ хийдэг. Оюутан өөрийн судалж буй хичээлийн үнэлгээг системээрээ харж, бусад оюутантай харьцуулах боломжтой. Япон судлалын салбарын оюутнуудын голч оноо нь сүүлийн 5 жилд 3.3.-аас буурч 2.01 болсныг анхаарч, дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үнэлгээний олон төрлийн аргазүйг ашигладаг, тэр дундаа Блумийн таксоном, рубрик арга, сорил, цахим сорил, гүйцэтгэлд суурилсан ур чадварын үнэлгээ г.м.
- Хичээл бүрийн онцлогт тохирсон үнэлгээний төрөл, хэлбэрийг сонгон хэрэглэдэг байна. Оюутнуудын дүнгийн нормал тархалтын шинжилгээг сургуулийн хэмжээнд програмаар хийдэг.
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалтыг сургуулийн болон хөтөлбөрийн хэмжээнд хийж, дүн шинжилгээ хийдэг. Оюутан өөрийн судалж буй хичээлийн үнэлгээг системээрээ харж, бусад оюутантай харьцуулах боломжтой.

Анхаарах асуудал:

- Япон судлалын салбарын оюутнуудын голч оноо нь сүүлийн 5 жилд 3.3.-аас буурч 2.01 болсныг анхаарч, дүн шинжилгээ хийх шаардлагатай.
- Зарим хичээлийн үнэлгээ мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлох Course Learning Outcomes-тай хэрхэн уялдаж байгаа нь тодорхойгүй.

Зөвлөмж:

- Бүх хичээлийн үнэлгээний хэмжүүрийг мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж буй Course Learning Outcomes-тай уялдуулан сайжруулах.
- Үнэлгээнд суралцагчийн өөрийн үнэлгээг нэвтрүүлэн ажиллах.

Орос:

- МУБИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооноос баталсан “Үнэлгээний даалгавар боловсруулах шаардлага, зөвлөмж”-ийн шаардлагад нийцүүлэн багш бүр өөрийн заадаг хичээлүүдийн үнэлгээний даалгаврыг танин мэдэхүйн түвшин бүрээр тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага, хичээлийн үр дүн /CLO/-г үнэлэх байдлаар боловсруулж, үнэлгээний сан бүрдүүлж тогмол сайжруулж ирсэн. Үүний нотолгоо нь: .1. 2017.04.16-нд багш бүр заадаг хичээлээрээ үнэлгээний сан бүрдүүлж Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгсөн. 2. 2018.04.18-нд багш нар заадаг хичээлийн үнэлгээний даалгаврын сангаа багшийн вэбд байршуулсан. 3. 2018.05.09-нд Орос хэл, арга зүйн тэнхимийн “Орос хэлний багш” хөтөлбөрийн төгсөлтийн үнэлгээний даалгаврын сангийн шалгуурыг боловсруулж хөтөлбөрийн албанд хүлээлгэн өгсөн. 4. 2018.05.20-нд мэргэжлийн хичээлийн төгсөлтийн онлайн шалгалтыг амжилттай туршсан. 5. 2019.05.11-нд шинэчлэн сайжруулсан үнэлгээний даалгавраар хоёр дахь удаа төгсөлтийн онлайн шалгалтыг амжилттай зохион байгуулсан.
- Суралцагч өөрийн сурлагын ахиц, амжилтад дүн шинжилгээг “Оюутны вэб”-ээр дамжуулан хийх боломжтой болсон.
- Удирдлага, мэдээллийн систем /ULMS/-ээс багшийн үнэлгээний нормаль тархалтыг харж дүн шинжилгээ хийх боломжтой болсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Сонгон суралцаж байгаа хичээлүүдийн сонголт, сурлагын дүнд шинжилгээ хийж, огт сонгохгүй байгаа шалтгааныг тодорхойлох, шаардлага хичээл гэмж оруулах зэргээр сонголттой хичээлийн төлөвлөгөөг уян хатан болгоход анхаарах

Зөвлөмж:

- Төгсөлтийн шалгалтаас бусад хичээлийн сорил, шалгалт, үнэлгээг шат дараатай цахимд шилжүүлэх.

Солонгос: 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Хятад хэл: 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Япон хэл: 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Орос хэл: 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Хичээлийн 3 танхимд сургалт явуулдаг.
- 2 ухаалаг танхимтай
- Сургалтын анги танхим, лабораторийн хангамж хүрэлцээний судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабораторийн хангамж хүрэлцээг сайжруулах арга хэмжээг жил бүрийн засвар болон хамтран ажилладаг төр, хувийн хэвшил, гадаад дотоодын байгууллагатай хамтран хэрэгжүүлж ирсэн. Хичээллэх байр, орчны үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааг бодитой хийдэг. Хятад хэлний багш нарт ажиллах материаллаг нийтлэг орчин бүрдсэн.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслийн хангамж хүрэлцээ их сургуулийн түвшиндээ сайн. Хятад хэлний сургалтанд 2018-2019 оны хичээлийн жилд 179 оюутантай, хичээлийн 4-р байрны 204 м² талбай бүхий 303,306,1006 тоот үндсэн танхимтай. 1 оюутанд 1,2м² талбай ногддог. Мөн лекцийн их танхим (12-р байрны 201, 303, 311, 312 анги), компьютерийн лаборатори (2-р байрны 504, 505), лингафоны кабинет (4-р байрны 205, 403) зэрэгт сургалтын үйл ажиллагааг давхар явуулдаг. Эдгээрийг оруулан тооцвол нэг оюутанд 2,3 м² талбай ногдож байна гэж үзэх боломжтой.
- Хятад хэлний сургалтын багш нарын хэрэгцээнд тэнхимийн 3 компьютер, канон, сургалт явуулдаг бүх анги проектороор хангагдсан, мөн 4-305 ухаалаг анги ашиглах боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабораторийн хангамж хүрэлцээний судалгааг хийсэн, зохих үнэлэлт дүгнэлтийг холбогдох сэтгэл ханамжийн судалгаагаар баримтжуулан бодитой өгсөн. Холбогдох засвар үйлчилгээ, хангамжид их сургуулийн захиргаа анхаарч ажилладаг тул япон хэлний багш нарт ажиллах материаллаг нийтлэг орчин бүрдсэн.
- 2018-2019 оны хичээлийн жилд сурч байгаа 50 оюутан 4-р байрны 301,507 үндсэн ангид хичээллэдэг. Эдгээр танхим нь 108м² талбайтай, нэг оюутанд 2,16 м² талбай ногддог. Эдгээрээс гадна хэлний лабораторийн 305,403, компьютерийн лаборатор 504,505-ийг бүгд 204 м² талбай давхар ашигладаг.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгслийн хангамж хүрэлцээ их сургуулийн түвшиндээ сайн. Хичээллэх байр, орчны үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгааг бодитой хийдэг. Япон хэлний багш нарт ажиллах материаллаг нийтлэг орчин бүрдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Салбарын номын санг ашиглах тал дээр багш оюутнууд хамтран ажиллах нөхцөл, уур амьсгал бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Хэлний лабораторийг ашиглах боломж хомс байдаг нь ажиглагдсан.

Зөвлөмж:

- Хэлний лаборатори байгуулан ажиллах тал дээр сургуулийн захиргаанаас тодорхой бодлого хэрэгжүүлэх.

ОРОС:

- Хичээллэх байрны талбайгаас нэг оюутанд ногдох норм, нормативыг орос хэлний сургалтанд ашиглаж буй нөхцөлд 90,4% хувь хангаж байгаа, үлдэх 9,5-ийг цаашид хангах хэрэгцээ байгаа гэж үздэг, тухайлбал, лекцийн суудалд ногдох талбай 1,25 байгаа /зүй нь 2,2м²/, профессорын өрөө байхгүй г.м.
- Орос хэлний багш нар хичээлийн 6 ангид сургалт явуулдаг, хичээлийн бус цагаар клуб, семинар зэрэг арга хэмжээ зохион байгуулахад хүрэлцээтэй. Танхимууд зохих туслах төхөөрөмжөөр тоноглогдсон. 205 тоот ангийг багш, оюутнуудын хүчээр тохижуулсан. Сургуулийн захиргаанаас сургалтын орчин, тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг үе шаттай сайн зохион байгуулж холбогдох засвар, үйлчилгээг тогтмол хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Сургалтанд U-Class-ийн иж бүрдэл програм ашигладаг.
- Хэлэхүйн дөрвөн чадварын хичээлийн үндсэн сурах бичиггүй. Хичээлийг багш нарын бэлдсэн гарын авлага дээр үндэслэн явуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Хэлэхүйн дөрвөн чадварын хичээлд сурах бичгийн олон улсын стандартыг хангасан, залгамж холбоо, уялдаа бүхий, сурах бичиг ашиглах.
- Солонгос хэлний Смарт ангид виндоус програм суулгаж ашиглалтыг сайжруулах хэрэгтэй.

ХЯТАД:

- Хятад хэлний сургалтын хэрэглэгдэхүүн, номын нөөцийг сургууль болон Күнзийн институтын дэмжлэгэтэйгээр бүрдүүлдэг. Хятад хэлний сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, сэтгэл ханамжийн талаарх судалгааг вэбээс харах боломжтой. Оргил ачааллаас бусад үед интернетийн хурдны сааралт бага байдаг, оюутнууд сургуулийн Wi-Fi-г төлбөргүй ашигладаг.
- Сургалтанд MC оффисийн лицензтэй програм, U-class, Smart class, ханзны 2 төрлийн програм, Online test HSK, Articulate Quiz maker болон судалгааны SPSS программыг оюутантай ажиллах, сургалтын мэдээлэл өгөх, боловсруулахад ашигладаг.
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг хэвлэмэл болон электрон байдлаар хүртээмжтэй хангасан.
- Е-контент түвшинд магистр, докторын сургалтанд ашиглаж ирсэн, бакалаврын сургалтанд энэ улирлаас эхлэн ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Одоо сурч буй оюутны тоон харьцаанд авч үзвэл япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн, номын нөөц хангалттай сайн бүрдүүлсэн, япон хэлний сургалтыг дэмжих төслийг 3 жил дараалан амжилттай хэрэгжүүлсэн, харин япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүний ашиглалт, сэтгэл ханамжийн талаархи судалгааг вэбээс харах боломжтой
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг хэвлэмэл болон электрон байдлаар хүртээмжтэй хангасан.
- Сургалтанд MS office болон U-class, Smart class-ийн орчинд Digital Language Lab System програм, мөн Online test JLPT, Macromedia Flash, Articulate Quiz maker ашигладаг. Судалгааны дүн мэдээ боловсруулахад SPSS програм ашигладаг.
- Е-контент түвшинд япон хэлний сурах бичиг дагалдан ирсэн боловсруулсан сургалтын материалыг өргөн ашигладаг. Япон хэлийг сурахад Япон сангийн япон хэлний боловсролын стандартын сайт, Минна но Can-do-гийн зэрэг 3 сайтыг япон хэл сурах софт орчны бүрдүүлэлтэд ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон хэлний сургалтыг дэмжих төслийг 3 жил дараалан амжилттай хэрэгжүүлснээр ном сурах бичгийн сангаа нэмэгдүүлж чадсан.

Анхаарах асуудал:

- Үндсэн сурах бичиг нь оюутны тоогоор байдаггүй тул хувилж ашигладаг.
- Үндсэн сурах бичиг болон нэмэлт сургалтын хэрэглэгдэхүүнд Японы түүх, уран зохиол, орон судлалын ном сурах бичиг, түүнчлэн япон хэл судлал, япон хэл заах аргатай холбоотой онолын ном, түүнчлэн япон хэлний унших, бичих чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн ном цөөн байгааг анхаарууштай.

Зөвлөмж:

- Гадаад дотодод хийгдсэн сүүлийн үеийн ном сурах бичиг, бусад сургалтын хэрэглэгдэхүүнийг оюутны тоогоор номын сандаа худалдан авах тал дээр санаачлагатай ажиллах, сургуулийн захиргаанд хүсэлт, шаардлага тавьж ажиллах нь зүйтэй.
- Тодорхой төлөвлөгөөний дагуу Е-контент түвшинд сургалтын материал боловсруулах шаардлагатай.

ОРОС:

- ОХАЗТ-ийн фондын орос хэлний сурах бичгийн 50% нь сонсох CD-тэй, хоёр хичээлээр хэвлэмэл үзүүлэн 5-15 ширхэгийг сургалтанд ашиглахын зэрэгцээ багш нар интернетийн сургалтын материал, өөрсдийн бэлтгэсэн цахим хичээлийг ашигладаг. Багш нар MS office, Free quiz maker, Google education. Hot potatoes, Movie Maker зэрэг програм ашигладаг.
- Их сургууль, салбар сургуулиас сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийг байнга өгдөг.
- Лекц, семинарын хичээлд Power point байнга ашигладаг, улсын шалгалтын онлайн тестийн санг жил бүр 20-30% шинэчилдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оросын эрдэмтэд, заах арга зүйчдийн зохиосон шилдэг сурах бичиг, гарын авлагыг ашиглахын зэрэгцээ гадаад хэл сурч байгаа улс үндэстний онцлогч тохирсон буюу монгол оюутанд тохирсон онол, арга зүйн өндөр түвшинд боловсруулсан сурах бичгүүдийг тэнхимийн эрдэмтэн багш нар зохиож сургалтад хэрэглэж байгаа туршлага байна. Үүнд: С.Эрдэнэмаам “Практическая грамматика”, З.Баярчимэг “Пособие по современному русскому языку”, Ш.Цолмон, Б.Анар “Страноведение”, Ц.Сэрээнэн, Р.Ургамал “Развитие чтения 1”

Анхаарах асуудал:

- З.Баярчимэг багшийн зохиосон “Пособие по современному русскому языку” гарын авлагыг хөтөлбөрийн “Орос хэлний онол” хичээлд зориулсан байна. Хичээлийг “Орос хэлний онол” гэснээс “Орчин цагийн орос хэл” гэх нь шинжлэх ухаан, онолын талаас илүү тохиромжтой болов уу.

Зөвлөмж:

- Оросын гадаад хүнд зориулсан орос хэлний сургалтын хэрэглэгдэхүүнийг сургалтандаа түлхүү хэрэглэх

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Жил бүр “Korea Foundation”, БНСУ-ын ЭСЯ-аас ном захиалж, солонгос номын фондыг өргөтгөн шинэчилдэг.
- Солонгос хэлний багш нар өөрсдөө зохиосон 11 нэрийн сурах бичиг, гарын авлагыг хэрэглэдэг.
- 2000 гаруй ном сурах бичиг, аудио, видео материал бүхий тэнхимийн номын сантай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Тэнхим дээр хятад хэлний үндсэн сурах бичиг хүрэлцээгүй (87 ш) тул хувиран олшруулж хэрэглэдэг. Нэмэлт ном сурах бичиг 20 нэр төрлийн 32 ш байдаг.
- Күнзийн институтэд 13 нэрийн 546 сурах бичиг гарын авлага байгааг оюутнууд ашиглах боломжтой. Оюутнууд Күнзийн институтээс сурах бичиг худалдан авах, түрээслэх байдлаар ашиглаж ирсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Япон хэлний үндсэн сурах бичиг, гарын авлагын хангамж сайн, суралцагчид сэтгэл ханамжтай байдаг нь уулзалт ярилцлагаас харагдсан.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгааг багш нартай хийх уулзалтын үеэр тодруулах, тоон баримт нэмэж авах шаардлагатай
- Минна но сан болон энэ сангийн сургалтын материал боловсруулах сайт, бусад сайтыг хэрхэн ашигладаг талаар тодруулах шаардлагатай.
- “Япон хэлний сургалтыг дэмжих төсөл”-ийг Япон сангийн тусламжтай 2014-2016 онд 3 жил хэрэгжүүлж 407798 ¥-ийн тусламж авч сургалтын хэрэглэгдхүүн захиалах төсөл хэрэгжүүлсэн. Сүүлийн 5 жилд 500 мянга орчим ¥-ийн 200 гаруй ном тусламжаар авсан. Одоогоор япон хэлний сургалтын фондод 600 орчим ном, сурах бичиг, толь бичиг байгаагийн ихэнх нь японд сургалтын зориулалтаар хэвлэгдсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2014-2016 онд 3 жил дараалан “Япон хэлний сургалтыг дэмжих төсөл”-ийг Япон сангийн тусламжтай хэрэгжүүлж 407798 иений тусламж авч сургалтын хэрэглэгдэхүүн захиалах төсөл хэрэгжүүлсэн. Нийтдээ сүүлийн 5 жилд 500 мянга орчим иений 200 гаруй ном тусламжаар авсан. Одоогоор япон хэлний сургалтын фондод 600 орчим ном, сурах бичиг, толь бичиг байгаагийн ихэнх нь японд сургалтын зориулалтаар хэвлэгдсэн

Анхаарах асуудал:

- Дотоодод хэвлэгдсэн япон хэлний ном, сурах бичиг, толь бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүл хомс байгаа нь ажиглагдсан.

Зөвлөмж:

- Дотоодод хэвлэгдсэн япон хэлний ном, сурах бичиг, толь бичиг, эрдэм шинжилгээний сэтгүүүүдийг жил бүр тодорхой төсвийн дагуу авдаг болох шаардлагатай.

ОРОС:

- Орос хэлний сургалтанд ашиглах монгол хэлээр 23 нэр төрөл, орос хэлээр 499 нэр төрлийн 2954 ном сурах бичиг ашигладаг. Тэнхимийн багш нар багийн бүрэлдэхүүнээр 3 хичээлийн сурах бичиг гаргасны дээр профессор багшийн оролцоотойгоор “Большой академический русско-монгольский словарь” төсөлд амжилттай оролцож эхний 3 боть хэвлэгдсэн.
- ОХУ-ын байгууллагууд, Оросын шинжлэх ухаан соёлын төвийн тусламжтайгаар CD, DVD –ээр 730 ширхэг сурах бичиг, уран зохиолын ном авч фондоо баяжуулсан
- Багш, оюутнууд МУБИС-ийн /LIB4U Net vision/ номын сан, электрон эх үүсвэрээр орос болон бусад улсын 10 төрлийн цахим санг ашиглах боломжоор хангагдсан. Мөн тэнхимийн дэргэдэх номын фондоор оюутнууддаа байнга үйлчилдэг. Энд тэнхимийн багш нарын шинээр зохиосон 3 нэрийн сурах бичиг ашиглаж байгаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчид тэнхимийн болон сургуулийн номын сан, бусад нээлттэй эх сурвалжаас авч хэрэглэх сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдсан.

Анхаарах асуудал:

- Оюутан сурах бичиг, гарын авлагыг дамжуулж хэрэглэхгүй, өөрийнх байлгах талаар арга хэмжээ авах, сурах бичиг гарын авлагын үнийг сургалтын төлбөрт шингээж багш нар ном борлуулдаггүй байх

Солонгос: 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
 Хятад хэл: 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
 Япон хэл: 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
 Орос хэл: 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Солонгос хэлний сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээлийн стандарт, хөтөлбөрийг 2015, 2018 онд шинэчлэн боловсруулж батлуулан мөрдөж байна.
- Багш нарын бүтээлийн сантай сургуулийн вэбийн 7 төрлийн дэд системээс танилцах боломжтой.
- Сургуулийн вэб хуудасны 5 төрлийн дэд системээс оюутантай ажиллах боломж, хөтөлбөрийн талаар санал, гомдол, явцыг хянах, эргэх холбоо барих өргөн боломж олгодог.
- Багш зааж буй хичээлийн үр дүнд анализ хийснээр дараагийн сургалтаа төлөвлөх сайжруулах боломжтой.
- 2017 оноос сургалтын үйл ажиллагааг дэмжсэн мэдээллийн ухаалаг систем бүрэн нэвтэрч багш нар онлайн курс төлөвлөлт хийх, даалгаварын сан бүрдүүлэх, онлайн үнэлгээ авах, боловсруулалт хийх ажил жигдэрсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлаар хөтөлбөрийн талаар хэлэцэн холбогдох шийдвэр гаргадаг, тэмдэглэлтэй.
- НХУС ба тэнхимийн зүгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын чанар сайжруулахад чиглүүлж багш нарыг зохих удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд нь үнэлгээ дүгнэлт өгдөг байна. Холбогдох судалгааг тус их сургуулийн “Мэдээллийн технолог, Зайн сургалтын алба” болон хятад хэлний багшийн цахим вэб сайтаар оюутны сэтгэл ханамжийн судалгаанд өгсөн үнэлгээний тусламжтайгаар хийж иржээ.
- 2014-2019 онд оюутнуудаас нийт 163 санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Багш нарт оюутнуудаас өгсөн сэтгэл ханамжийн үнэлгээ 86-88% байгаа.
- Хятад хэлний сургалтанд бусад мэргэжлийн хамт 2014 оноос удирдлага мэдээллийн систем (ULMS) нэвтрүүлж багш, оюутны мэдээллийн нэгдсэн санд хандан холбогдох мэдээллийг цаг алдалгүй авах, бодит мэдээлэл дээр үндэслэсэн тооцоо судалгаа хийж ажиллах боломжтой болжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэлтэй.
- НХУС ба тэнхимийн зүгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтын чанар сайжруулахад чиглүүлж багш нарыг зохих удирдлагаар хангаж, хэрэгжилтэнд нь үнэлгээ дүгнэлт өгдөг байна. Үүнд холбогдох судалгааг тус их сургуулийн “Мэдээллийн технологи, Зайн сургалтын алба” болон япон хэлний багшийн цахим вэб сайтаар оюутны сэтгэл ханамжийн судалгаанд өгсөн үнэлгээний тусламжтайгаар хийж иржээ.
- Япон хэлний сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт заавал суралцах 37 хичээл, сонгон суралцах 8 хичээлийн стандарт, хөтөлбөрийг баталгаажуулсан байна. Мөн багш нэг бүр заасан хичээл тус бүрээр суралцагчдаас үр дүнгийн санал асуулга авдаг.
- Япон хэлний сургалтанд бусад мэргэжлийн хамт 2014 оноос удирдлага мэдээллийн систем (ULMS) нэвтрүүлж багш, оюутны мэдээллийн нэгдсэн санд хандан холбогдох мэдээллийг цаг алдалгүй авах, бодит мэдээлэл дээр үндэслэсэн тооцоо судалгаа хийж ажиллах боломжтой болжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагаа үе шаттай, тогтвортой хэрэгжиж ирсэн нь хичээлийн стандарт, хөтөлбөрүүдийг удаа дараа шинэчилж сайжруулахад зохих нөлөө үзүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Хичээл тус бүрийн агуулга, арга зүйтэй холбоотой суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаанд анализ хийсэн байдал дутмаг.

Зөвлөмж:

- Хичээл тус бүрийн агуулга, арга зүйтэй холбоотой суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг хийж хэвших, ингэснээр хичээлийн хөтөлбөрийг сайжруулах, бусад эргэх холбоог сайжруулахад анхаарч ажиллах шаардлагатай.

ОРОС:

- МУБИС, НХУС-ийн хөтөлбөрийн хороодын ажил тогтмолжсон, хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэлтэй, тухайлбал, сүүлийн 4 жилд Хөтөлбөрийн нэгдсэн алба, Хөтөлбөрийн ерөнхий хороо 41 удаа хэлэлцүүлэг хийсэн.
- ОХАЗТ –ийн багш нар 3 жилийн хөгжлийн хөтөлбөрийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж үр дүнг тооцдог, тухайлбал, 2019 оны 1 сарын 9-нд хөтөлбөрийн биелэлтийг шалгаж тооцсон.
- Орос хэлний хөтөлбөртэй холбоотой санал гомдол нь хичээл сонголт, дадлага, үргэлжлүүлэн хичээл үзэх, төлбөрийн асуудлаар их төлөв гардаг, сүүлийн 5 жилд 163 санал хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт оюутнаас авсан судалгаагаар сэтгэл ханамж 90%, түүнээс дээш байгаа.
- 2014 оноос удирдлага мэдээллийн систем (ULMS) нэвтрүүлж багш, оюутны мэдээллийн нэгдсэн санд хандан холбогдох мэдээллийг цаг алдалгүй авах, 10 гаруй төрлийн цахим хандлагын эх үүсвэрээр оюутнуудтай харилцаж тэнд буй бодит мэдээлэл дээр үндэслэсэн тооцоо судалгаа хийж ажиллах боломжтой болсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт оролцогч талууд нягт уялдаатай ажилладаг.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- 2004 оноос БНСУ-ын Боловсролын их сургуультай хамтран “Солонгос хэл, соёл” сэдвийн хүрээнд өвөл зуны сургалт зохион байгуулж ирсэн.
- Пусан Гадаад хэлний сургууль, Гуанжу Боловсролын их сургууль, Жэжү их сургууль, Канвон их сургууль, Дун А их сургууль, Гэмён их сургууль, Гёнги их сургууль, Бэжа их сургууль зэрэг 10 гаруй их сургуультай багш, оюутан солилцох, судалгаа шинжилгээний хамтын ажиллагааны гэрээтэй.
- -2017 оноос хойш Пусаны олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран Сонгино хайрхан дүүргийн 21-р хороонд нийгмийн сайн дурын үйлчилгээ (эрүүл мэнд, сургуулийн өмнөх боловсрол г.м.) зохион байгуулж ирсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хятад судлалын багш нар БНХАУ-ын Nanban байгууллага, БНХАУ-ын Зүүн хойдын Багшийн их сургууль, Улаанбаатар хот дахь БНХАУ-ын Соёлын төв, Хятадын төв банкны салбар, дотоодын их дээд болон ЕБС-иудтай идэвхитэй хамтын ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Ази судлалын Олон улсын эрдэм шинжилгээний хуралд хятад хэлний багш нар 5 жил дараалан оролцож 12 илтгэл хэлэлцүүлсэн.
- БНХАУ-ын Зүүн хойдын Багшийн их сургуультай хамтран хятад хэлний 2,4-р курсын оюутнууд жил бүр 1 жил хэлний дадлага хийдэг. Үүний зэрэгцээ 2+2 хөтөлбөрөөр 2015-2019 онд хятад хэл судалж буй 198 оюутан тэтгэлэгт хамрагдан суралцсан.
- Хятад хэлний багш мэргэжлээр 2014-2019 онд нийт 128 оюутан төгссөн. Төгсөгчдийн ажил мэргэжлийн судалгааг 2008 оноос илүү нарийвчлалтай хийдэг болсон ба 20 гаруй ажил олгогч аж ахуйн нэгжтэй холбогдон төгсөгчдийг ажилд зуучилдаг.
- Хятад хэлээр төгсөгчдөөс 42 нь нэг улирлаас нэг жилээр мэргэжил дээшлүүлэх курс, магистрын сургалтанд хамрагдсанаас гадна төгсөгчдийн

давтан сургалтанд 2014-2018 онд нийт 417 төгсөгч, ЕБС-ийн хятад хэлний багш нарыг Күнзийн институт болон Зүүн хойдын Багшийн их сургуулийн мэргэжилтэн багш нартай хамтран зохион байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- НХУС ба тэнхимийн зүгээс суралцагчдын идэвхийг дэмжих, гадаад болон дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглүүлж иржээ. Тухайлбал, гадаад дотоодын их сургуулиудын ази судлал, япон судлалын тэнхим, Япон-Монгол төвтэй байнгын хамт ажиллагаатай, хамтарсан сургалт-семинар, симпозиум, олон улсын эрдэм шинжилгээний хурал (“Япон хэлний боловсролын сипозиум”, “Япон хэлний боловсролын эрдэм шинжилгээний хурал” г.м.) зохион байгуулж иржээ.
- Сүүлийн 3 жилд Азийн их сургуульд 3, Акита их сургуульд 8, Хёого их сургуульд 3, Айчи боловсролын их сургуульд 1 тус бүр тэтгэлэгтэй сургасны зэрэгцээ Айчи их сургуулиас жил бүр багш, оюутан ирж ажиллах, суралцах хамтын ажиллагаа хэрэгжиж иржээ.
- Япон хэлний багш нарын холбоотой байнга хамтран ажиллаж Жайка байгууллага, их болон дунд сургуульд ажиллаж буй япон хэлний багш нар, монгол сурагчдад зориулсан сурах бичгийн төсөл хэрэгжүүлж байгаа багш нартай хамтран хичээл сургалтыг долоо хоногийн нэг өдөр тогтмол явуулж ирсэн байна. Мөн Айчи их сургуулийн боловсролын үзэсгэлэнд сургуулиа сурталчилахад оролцон 18 оюутан илгээх зэрэг тодорхой үр дүнтэй хамтын ажиллагаа хэрэгжиж иржээ.
- Япон хэлээр 18 удаагийн төгсөлтөөр 300 орчим япон хэлний мэргэжилтэн бэлтгэж төгсөгчдийн 40 орчим хувь нь Японд сурч ажиллаж амьдарч байна. Улсын хэмжээнд одоо ажиллаж буй япон хэлний 250 орчим багш байгаагийн 20% нь НХУС-ийн төгсөгчид байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Азийн их сургууль, Акита их сургууль, Хёого их сургууль, Айчи боловсролын их сургуультай нягт хамтын ажиллагаатай явж ирсэн ба жил бүр багш, оюутан ирж ажиллах, суралцах хамтын ажиллагаа хэрэгжиж иржээ.

Анхаарах асуудал:

- Японы Засгийн газрын тэтгэлэгт япон хэл, соёл судлаач хөтөлбөрт тэнцэж хамрагдсан оюутны тоо харьцангуй цөөн байна.

Зөвлөмж:

- Оюутан солилцооны хөтөлбөрүүдийг улам нэмэгдүүлэх тал дээр анхаарч, суралцах хугацаандаа оюутан бүр ямар нэг хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай.

ОРОС:

- Орос хэлний багш нарын зүгээс орос хэл судлаж сурагчид, оюутнуудын идэвхийг дэмжих, орос хэлний сурах бичиг гарын авлага зохион их дээд болон дунд сургуульд зориулан улсын захиалгаар ажлын багт орж хэвлүүлэх, орос хэлний багш нарын эрдэм шинжилгээний ажлыг дэмжихэд чиглэсэн гадаад болон дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд амжилттай ажиллав. БСШУЯ, ГХЯ, Монгол улсад сугаа ЭСЯ-ууд болон Монгол улс, ОХУ-ын ШУА-тай хамтран захиалгат ажил, олон улсын төсөл хэрэгжүүлж 4 боть толь бичиг гаргах, ОХУ-ын Уралын их сургууль, ОХУ-ын Халимагийн улсын их сургууль, ОХУ, Казахстан, Узбекистан, Германы болон дотоодын их дээд сургуулиудын эрдэмтэн, судлаачдын бүтээл судалгаагаар хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний хурлууд (“Русский язык как иностранный в современном образовательном пространстве”, “Русский язык как иностранный: традиции и инновации в методике преподавания”, “Русский язык как иностранный: вчера, сегодня, завтра”, “Европ судлал-I,II,III: хэл, соёл, олон улс, орон судлал”, “Гадаад хэлний сургалтанд харилцааны арга ашиглах нь сэдэвт их семинарыг 2 удаа, г.м.”) амжилттай зохион байгуулсан.
- Нийслэлийн ерөнхий боловсролын 18 дунд сургууль, Монголын ОХУЗБ нарын холбоо, Оросын шинжлэх ухаан, соёлын төв зэрэг байгууллагуудтай хамтран ЕБС-ийн 9-12-р ангийн сурагчдын орос хэлний улсын олимпиадыг жил бүр зохион байгуулахын зэрэгцээ ЕБС-д зориулсан орос хэлний сурах бичиг гарын авлага, Багшийн ном, сургалтын хөтөлбөр зэргийг амжилттай зохион сургалтанд хэрэглэж байна. Орос сургуулиудын 8-10-р ангийн сурагчдын дунд “Изумруд” олимпиад, олон улсын оюутны хэл шинжлэлийн лагерь амжилттай зохион байгуулсан. Мөн орос хэл судлаж буй оюутнуудыг ОХУ-ын Халимагийн Улсын их сургуульд 50 гаруй оюутан солилцоо, бүтэн жилээр дадлага хийлгэж кредит тооцсон.
- Төгсөгчдийг дэмжих зорилгоор “Гадаад хэлний боловсрол”, “Гадаад хэлний хэл шинжлэл” 2 мэргэжлийн чиглэлээр магистрын сургалт явуулдаг. Багшийн мэргэжил рүү хөрвөх сургалтыг мөн хоёр чиглэлд зохион байгуулдаг. Хот хөдөөгийн багш нарт зориулсан мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтыг жил бүр 1-2 удаа явуулж БМДИ-тэй хамтран 3 удаагийн сургалтаар 90 гаруй багш нарыг хамарч сертификат олгосон бөгөөд оролцогчид сэтгэл ханамж сайн байсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Бакалаврын нэг оюутанд ногдох зардал өмнөх хичээлийн жилээс 77,9-өөр (4,9% орчим) өссөн. Энэ нь хөтөлбөрийн нэг кредитийн үнэлгээний өсөлт (8,4% орчим) -ийг тусгаж байна.
- “Солонгос хэлний цогц сурах бичиг” анхан, дунд, дээд шатны сурах бичиг хандиваар, БНСУ-ын KOICA олон улсын хамтын ажиллагааны санхүүжилтээр солонгос хэлний сургалтанд ашиглах хувилагч, хэвлэгч машин, “Солонгос хэлний ухаалаг анги” нийт 103 сая илүү төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн санхүүжилтын эх үүсвэрийг төрөлжүүлэх

ХЯТАД:

- Дорно дахины хэлний тэнхимийн 2018-2019 оны хичээлийн жилийн орлого зарлагын балансаас үзвэл хөтөлбөрийн санхүүжилт нь үндсэн нэг төрлийн буюу сургалтын үйл ажиллагааны орлого (471371,5 мян.₮) байна.
- МУБИС-ийн дунджаар бакалаврын нэг оюутанд ногдох зардал 2018-2019 оны хичээлийн жилд 1583,96 буюу өмнөх хичээлийн жилээс 77,9-өөр (4,9% орчим) өссөн байна. Энэ нь хөтөлбөрийн нэг кредитийн үнэлгээний өсөлтийг тусгаж байна.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг задаргаанд тэнхимийн ашиг 131163,3 (27.3% орчим) байгааг үзвэл хөтөлбөрт зарцуулагддаг хэмжээ харьцангуй бага мэт байна. Мөн бусад зардал хэсэгт 33440,8 (ойролцоогоор 7%) байгааг тооцвол хөтөлбөрт зарцуулах зардлыг нарийвчлах боломж байгаа ажээ. Гэхдээ энд дурдсан 7 хувийг юунд, тухайлбал, хөтөлбөрийн шинэчлэлтэд зориулдаг эсэхийг магадлах хэрэгтэй юм.

- 2014 оноос бүрэлдхүүн сургуулийн орлогыг бие даасан данстай болгож өөрийн хөтөлбөрөөс олж буй орлогоо хуримтлуулан санхүүжилтээ тухайн данснаас авдаг болжээ. Мөн 2015 оны А/266 тоот тушаалаар баталгаажсан санхүүгийн журмаар санхүүгийн нэгж бүр өөрийн үйл ажиллагаан дээр тулгуурласан орлогоос хөтөлбөр тус бүрээр хуваарилалт хийж өгснөөр хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг хангах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.
- “Хятад хэлний гүүр” тэмцээнийг нийслэл, улсын хэмжээнд 2013-2018 онд зохион байгуулж уг тэмцээнд тус тэнхимийн хятад судлалын 19 оюутан тусгай байр, 2 дугаар байрны шагналыг авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Дорно дахины хэлний тэнхимийн 2018-2019 оны хичээлийн жилийн орлого зарлагын балансаас үзвэл хөтөлбөрийн санхүүжилт нь үндсэн нэг төрлийн буюу сургалтын үйл ажиллагааны орлого (471371,5 мян.₮) байна.
- Их сургуулийн дундажаар бакалаврын нэг оюутанд ногдох зардал 1583,96 буюу өмнөх хичээлийн жилээс 77,9-өөр (4,9% орчим) өссөн байна. Энэ нь хөтөлбөрийн нэг кредитийн үнэлгээний өсөлт (8,4% орчим) -ийг тусгаж байна.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг задаргаанд тэнхимийн ашиг 131163,3 (27.3% орчим) байгааг үзвэл хөтөлбөрт зарцуулагддаг хэмжээ харьцангуй бага мэт байна. Мөн бусад зардал хэсэгт 33440,8 (ойролцоогоор 7%) байгааг тооцвол хөтөлбөрт зарцуулах зардлыг нарийвчлах боломж байгаа ажээ. Гэхдээ энд дурдсан 7 хувийг юунд, тухайлбал, хөтөлбөрийн шинэчлэлтэд зориулдаг эсэхийг магадлах хэрэгтэй юм. Учир нь 2014 оноос бүрэлдэхүүн сургуулийн орлогыг бие даасан данстай болгож өөрийн хөтөлбөрөөс олж буй орлогоо хуримтлуулан санхүүжилтээ тухайн данснаас авдаг болжээ. Мөн 2015 оны А/266 тоот тушаалаар баталгаажсан санхүүгийн журмаар санхүүгийн нэгж бүр өөрийн үйл ажиллагаан дээр тулгуурласан орлогоос хөтөлбөр тус бүрээр хуваарилалт хийж өгснөөр хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг хангах нөхцөлийг бүрдүүлж өгсөн байна.
- Тайланд, Япон сангийн сурах бичгийн үнэ төлбөргүй буцалтгүй тусламж хэрэгжиж байгаа ба сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу японы харилцаа бүхий их сургуульд оюутан сурах, оюутан солилцоооны зардлын тодорхой хэсгийг Японы тал хариуцаж, Монголд оюутан солилцоогоор жил бүр ирэх оюутны зардлыг НХУС-аас хариуцдаг тухай дурдсан боловч тоо баримтжуулаагүй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон сангийн сурах бичгийн үнэ төлбөргүй буцалтгүй тусламж хэрэгжиж байгаа ба сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу японы харилцаа бүхий их сургуульд оюутан сурах, оюутан солилцоооны зардлын тодорхой хэсгийг Японы тал хариуцаж, Монголд оюутан солилцоогоор жил бүр ирэх оюутны зардлыг НХУС-аас хариуцдаг.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, онцлогт тохирсон санхүүжилт, багш дэмжих зардал гэх мэт дэмжлэгийн тогтолцооны хэрэгжилт тодорхойгүй байна.

Зөвлөмж:

- Сургуулийн зүгээс тухайн хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага, онцлогт тохирсон санхүүжилтийн тогтолцоог бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

ОРОС:

- 2018-2019 оны хичээлийн жилд ОХАЗТ –ийн орлого хоёр эх үүсвэртэй, сургалтын үйл ажиллагаанаас 256948 төгрөг, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанаас 7555140 төгрөг, нийт орлого 264533140 төгрөг болжээ.
- Нэг оюутанд ногдох дундаж зардал 158396 төгрөг байна.
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг задаргаанд тэнхимийн ашиг 41876,74 төгрөг (15% орчим) байгааг үзвэл хөтөлбөрт зарцуулагддаг хэмжээ харьцангуй бага мэт байна. Мөн бусад зардал хэсэгт 13335,2 төгрөг байна. Багш нарын туурвисан сурах бичиг, гарын авлагыг хэвлэхэд НХУС-аас хөрөнгө зарцуулж, бүтээгдэхүүнийг борлуулж олсон мөнгөний 30% хүртэл төвлөрүүлэх замаар сан бүрдүүлж багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих санг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа ажээ. Гэвч тэнхимийн бүтээлээр олсон орлого хэсэгт орлого тооцогдоогүй байгаа тайланг 2018-2019 оны хичээлийн жилийн ОХАЗТ-ийн орлого, зарлагын баланс /ӨҮТ-ийн 69-р тал/-аас ажиглаж болно.
- Төрөөс үзүүлэх дэмжлэг нь БСШУЯ болон Боловсролын хүрээлэнгээс зохион байгуулдаг үндэсний хэмжээний захиалгат ажлаас их төлөв бүрддэг байна. Энэ хүрээнд орос хэлний 21, 22, 23 дугаар олимпиад зохион байгуулах, ЕБС-ийн Суурь боловсролын сургалтын /гадаад хэл/ хөтөлбөр, БДБ-ын сургалтын /гадаад хэл/ цөм хөтөлбөр болон ЕБС-ийн орос хэлний сургалтын сурах бичиг зохиох, шинэчлэн боловсруулах ажил зонхилсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Тэнхимийн багш нарын бүрэлдэхүүн /6 багш/ орос хэлний багшийн мэргэжлийн элсэгчдийн тоотой харьцуулахад / нэг жилийн элсэлт 20-30—аас ихгүй байгаа/ их байгаа нь дан ганц орос хэлний багшийн хөтөлбөр санхүүгийн эрсдэлд оруулах магадлалтай.

Зөвлөмж:

- Орос хэлний бус мэргэжлийн ангийн суралцагчдын орос хэл сонгон судлах асуудалд анхаарал хандуулж, суралцагчдын тоог нэмэгдүүлэх.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Их сургууль, салбар сургуулийн вэб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, ТВ, радио, FM, Facebook, Youtube зэрэг бололцоот бүх сувгаар харилцагч байгууллага, төгсөгчид, оюутнууддаа хандан холбогдох мэдээллийг байнга өгч харилцдаг.
- Сургуулийн вэбийн 5 дэд системд элсэгчид, төгсөгчид, оюутантай ажиллах боломж бүрдүүлсэн нь хөтөлбөрийн хэрэгжүүлэлтээр суралцагчдын санал, гомдол, явцыг хянах боломж олгож байдаг.
- Солонгос хэл сурталчлах өдөр зохион байгуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Хөтөлбөр сурталчлах зорилгоор жил бүр 10-11-р сард “Хэл сурталчлах өдөр”, хаврын улиралд “Хятад хэлний баяр” зохион байгуулдаг.
- Хятад хэлний хөтөлбөрийн багш нар их сургууль, салбар сургуулийн вэб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, ТВ, радио, FM, Facebook, Youtube зэрэг бололцоот бүх сувгаар харилцагч байгууллага, төгсөгчид, оюутнууддаа хандан холбогдох мэдээллийг байнга өгч харилцдаг байна. Элсэлтийн болон төгсөгчдийн холбооны мэдээлэл, мэргэжил сурталчлах

өдрийн үйл ажиллагаа, БНХАУ-д хэлний дадлага хийдэг, энэ тухай мэдээллийг вэбсайт, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргадаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Япон хэлний багш бэлтгэх хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөө, тандан судалгааны талаар тайланд нарийвчлан тусгаагүй боловч энэ чиглэлийн арга хэмжээг орхигдуулсан гэж үзэх боломжгүй байна. Хөтөлбөрийг авч яваа мэргэжлийн багш цөөн буюу 4 багштай, тайлант хугацаанд хөтөлбөрийн мэргэжлийн хичээлийн стандарт, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулахад ихээхэн цаг хүч зарцуулсан байгааг харгалзан үзэх нь зүйтэй.
- Хөтөлбөрийг авч яваа багш нар их сургууль, салбар сургуулийн вэб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, ТВ, радио, FM, Face book, You tube зэрэг бололцоот бүх сувгаар харилцагч байгууллага, төгсөгчид, оюутнууддаа хандан холбогдох мэдээллийг байнга өгч харилцдаг байна. Элсэлтийн болон төгсөгчдийн холбооны мэдээлэл, мэргэжил сурталчлах өдрийн үйл ажиллагаа, ЕБС-ын Монгени, 54-р сургууль, Япон улсын Засгийн газрын КООСЕН төсөл, Япон сангийн “Контент танилцуулах төсөл” зэрэг байгууллага, нэгжүүдийн хамтын ажиллагаанд оролцдог байна. Мөн Айчи их сургуулийн боловсролын үзэсгэлэнд сургуулиа сурталчилахад оролцож оюутан илгээсэн, оюутан солилцоог японы бусад их сургуультай хамтран хэрэгжүүлдэг, энэ тухай мэдээллийг вэбсайт, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргадаг талаар тайланд бий.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжил сурталчилах үйл ажиллагааны хүрээнд ЕБС-ын Монгени, 54-р сургууль, Япон улсын Засгийн газрын КООСЕН төсөл, Япон сангийн “Контент танилцуулах төсөл” зэрэг байгууллага, нэгжүүдийн хамтын ажиллагаанд оролцдог байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр, мэргэжлээ олон нийтэд сурталчилах ажлын цар хүрээ хязгаарлагдмал байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөр, мэргэжлээ олон нийтэд сурталчилах ажлыг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх, мэдээлэл түгээх өөрийн гэсэн сувагтай болох.

ОРОС:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас үзвэл 2014-2019 онд 219 төгсөгчийн 74,4% ажил эрхэлж, үүнээс 14,1% нь мэргэжлийн бус салбарт ажиллаж байгаа ажээ.
- Хөтөлбөрийг авч яваа багш нар их сургууль, салбар сургуулийн вэб сайт, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, ТВ, радио, FM, Facebook, Youtube зэрэг бололцоот бүх сувгаар харилцагч байгууллага, төгсөгчид, оюутнууддаа хандан холбогдох мэдээллийг байнга өгч харилцдаг байна. Элсэлтийн болон төгсөгчдийн холбооны мэдээлэл, мэргэжил сурталчлах өдрийн үйл ажиллагаа явуулж иржээ. 2018-2019 оны хичээлийн жилд хөтөлбөр таниулах ажлыг ЕБ-ын 102, 93-р сургууль дээр хийсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, мэргэжлээрээ ажиллах талаар сургалтын явцад анхаарч ажил эрхлэгчтэй холбох, хөдөө орон нутгийн холбогдох байгууллагтай холбоо тогтоох, сургалтын төлбөр болон бусад үзүүлэтээр дэмжих талаар гэрээ байгуулж суралцах явдалд анхаарах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:**СОЛОНГОС:**

- 2014-2018 онд солонгос хэлний сургалт хариуцсан үндсэн орон тооны 3 багш сурах бичиг 3, өгүүлэл 23, илтгэл 5 хэлэлцүүлсэн.
- МУБИС, БНСУ-ын их дээд сургууль, НХУС-ийн хэрэгжүүлж ирсэн 7 төсөлд оролцож ажилласан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт.
- Хятад хэлний багш нар БНХАУ-ын Зүүн хойдын Багшийн их сургууль, Улаанбаатар хот дахь Күнзийн институт болон БНХАУ-ын Зүүн хойдын Багшийн их сургуулиудтай хэлний дадлагаар оролцоот сургалт зохион байгуулах, тэтгэлэгт хамруулах хамтын ажиллагааг тогмолжуулсан.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, явцын талаарх гол мэдээлэл нь их сургууль салбар сургуулийн вэбсайт, удирдлага мэдээллийн систем (ULMS)-ээр тус дамжин оюутан болон сонирхогч байгууллагуудад ил тод нээлттэй байдаг. Эдгээр мэдээллийн хэрэгсэл нь манай улсын дээд боловсролын стандарт, их сургуулийн шаардлагад нийцсэн зохион байгуулалттай, үйл ажиллагаа нь тогтмолжсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, явцын талаархи гол мэдээлэл нь их сургууль салбар сургуулийн вэбсайт, удирдлага мэдээллийн систем (ULMS)-ээр тус дамжин оюутан болон сонирхогч байгууллагуудад ил тод нээлттэй байдаг байна. Эдгээр мэдээллийн хэрэгсэл нь манай улсын дээд боловсролын стандарт, их сургуулийн шаардлагад нийцсэн зохион байгуулалттай, тогтмолжсон үйл ажиллагаатай байна.
- Япон хэлний багш нар Азийн их сургууль Акита их сургууль, Хёого их сургууль, Айчи боловсролын их сургуульд оюутан сургах, жил бүр багш, оюутан авч хамтран ажиллах, Япон улсын Засгийн газрын KOOCEN төсөл, Япон сангийн “Контент танилцуулах төсөл” зэрэг байгууллага, нэгжүүдийн хамтын ажиллагаанд оролцдог, энэ тухайгаа байнга мэдээлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар Facebook зэрэг цахим платформоор дамжуулан суралцагчид төгсөгчидтэйгээ харьцдаг.

Анхаарах асуудал:

- Сургалтын хөтөлбөрийг ил тод, нээлттэй байлгахад чиглэсэн үйл ажиллагааны цар хүрээ хязгаарлагдмал.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрийг ил тод, нээлттэй байлгахад чиглэсэн үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх.
- Тухайн салбарыг төгсөгчдийн нэгдсэн Facebook групптэй болж, мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмолжуулах.

ОРОС:

- Хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, явцын талаарх гол мэдээлэл нь их сургууль салбар сургуулийн вэбсайт, удирдлага мэдээллийн систем (ULMS)-ээр тус дамжин оюутан болон сонирхогч байгууллагуудад ил тод нээлттэй байдаг байна. Мөн сонин, тогтмол хэвлэлээр дамжуулан үйл ажиллагаагаа сурталчилдаг байна. Сүүлийн жилүүдэд тэнхимийн багш нарын шууд оролцоотойгоор их дээд сургууль, ЕБС, БДБ-д зориулсан улсын хэмжээний 20 орчим сурах бичиг гарын авлага зохиосон байна.
- Орос хэлний тэнхим өөрийн Facebook групптэй. “Русский язык” групп нь орос хэлний багш, оюутан, төгсөгчдийн 10 гаруй Facebook группыг хөтлөн мэдээлэл солилцдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Солонгос: 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Хятад хэл: 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Япон хэл: 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Орос хэл: 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Тус сургууль нь элсэлтийн бодлого, дүрэм журам, зарыг сургуулийн вэбхуудас, <http://www.mnue.mn> <http://burtgel.surgalt.mn> цахим хуудсаар дамжуулан түгээдэг.
- Шинэ элсэгчдийн өгөх шалгалтын төрөл, босго оноог жил бүрийн элсэлтийн журамд тусгаж 2-р сарын 1-ний дотор нийтэд зарладаг.
- Элсэлтийн дундаж оноо 2019-2019 оны хичээлийн жилд 515 болж буурсан, элсэгчдийн тоонд хот хөдөөгийн харьцаа зохистой буюу хөдөөний элсэгчид 44,1%-ийг эзэлдэг.
- Шинээр элссэн оюутан бүрт сургуулиас томилсон зөвлөх багшийн нэр, оюутны код, өрөөний хаяг, утас зэрэгтэй лавлах хуудас олгодог.
- Шинээр элсэгчдэд “Мэргэжлийн удиртгал” хичээлээр сургууль, мэргэжлээ танилцуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 1 гадаад оюутантай.

ХЯТАД:

- Тус сургууль нь элсэлтийн бодлого, дүрэм журам, зарыг сургуулийн вэбхуудас, <http://www.mnue.mn> <http://burtgel.surgalt.mn> цахим хуудсаар дамжуулан түгээдэг. Хятад хэлний багшийн ангид элсэхийг хүсэгчид мэргэжилд хамаарах ерөнхий шалгалтын босго оноог 400,450-аас доошгүй оноотой өгч, мөн HSK шалгалтыг 4,0 авбал багшийн ангид тэнцдэг. Хятад хэл багшийн мэргэжлээр 2014-2019 онд нийт 315 оюутан элсүүлсэн. Хятад хэлний энэ хөтөлбөрөөр элсэлт 2017-2018 оны хичээлийн жилд 57 байсан буюу өмнөх жилээс 10-аар нэмэгдсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 67 оюутан элсчээ. Элсэгчдийн дундаж оноо 2014-2015 оны хичээлийн жилд 565-аас 2018-2019 оны хичээлийн жилд 527 болж буурсан хандлага ажиглагдаж байна.
- Шинээр элссэн оюутан бүрт сургуулиас томилсон зөвлөх багшийн нэр, оюутны код, зөвлөх багшийн нэр, өрөөний хаяг, утас зэрэгтэй лавлах хуудас олгодог байна. Шинээр элсэгчдэд “Мэргэжлийн удиртгал” хичээлээр сургууль, мэргэжлээ танилцуулдаг бөгөөд номын сангаар үйлчлүүлэх заавар, эрүүл мэндийн даатгалд хамрагдах явц, кредит сонгон төлөвлөх, биелүүлэх журам, оюутны холбооны ажил болон бусад зайлшгүй шаардлагатай заавар журмыг заавал танилцуулдаг. Мөн жил бүр хятад хэлний баяр, танилцах өдөрлөг зохион байгуулж, цаашид суралцах итгэл үнэмшилтэй болгоход зориулсан ажил зохион байгуулдаг. Мөн улсын хэмжээний “Боловсролын үзэсгэлэн”

яармагаар сургуулиа танилцуулж багш мэргэжлээ сурталчилдаг ба элсэгчдэд хандсан мэдээлэл өгдөг байна.

- ӨYT-ийн хугацаанд гадаадаас бакалавр 2, магистратурт нэг суралцагч элсүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Тус сургууль нь элсэлтийн бодлого, дүрэм журам, зарыг сургуулийн вэбхуудас, <http://www.mnue.mn> <http://burtgel.surgalt.mn> цахим хуудсаар дамжуулан түгээдэг. Япон хэлний багшийн ангид элсэхийг хүсэгчид мэргэжилд хамаарах ерөнхий шалгалтыг өгч, авбал зохих 800 онооны 50-иас дээш хувийг авсан байх болзолтой. Япон хэл хөтөлбөрөөр өмнөх жилүүдтэй харьцуулахад элсэгчдийн тоо сүүлийн 2 жил дараалан бараг хоёр дахин нэмэгдсэн бөгөөд 2018-2019 оны хичээлийн жилд 30 оюутан элсчээ. Элсэгчдийн 64 хувийг Улаанбаатар хотын элсэгчид эзэлсэн байна. Элсэх хүсэлт гаргасан ба элссэн оюутны тоон харьцаа нэг түвшинд байна. Элсэгчдийн дундаж оноо 525-аас 543,4 болж нэмэгдсэн эерэг хандлага гарчээ.
- Шинээр элссэн оюутан бүрт сургуулиас томилсон зөвлөх багшийн нэр, оюутны код, зөвлөх багшийн нэр, ерөөний хаяг, утас зэрэгтэй лавлах хуудас олгодог байна. Шинээр элсэгчдэд “Мэргэжлийн удиртгал” хичээлээр сургууль, мэргэжлээ танилцуулдаг бөгөөд номын сангаар үйлчлүүлэх заавар, эрүүл мэндийн даатгалд хамрагдах явц, кредит сонгон төлөвлөх, биелүүлэх журам, оюутны холбооны ажил болон бусад зайлшгүй шаардлагатай заавар журмыг заавал танилцуулдаг. Мөн жил бүрийн хавар япон хэлний баяр, танилцах өдөрлөг зохион байгуулж, цаашид суралцах итгэл үнэмшилтэй болгоход зориулсан ажил зохион байгуулдаг байна. Мөн улсын хэмжээний “Боловсролын үзэсгэлэн” яармагт жил бүр оролцон сургуулиа танилцуулж мэргэжлээ сурталчилдаг ба элсэгчдэд хандсан мэдээлэл өгдөг байна. Гадаад оюутан богино хугацааны солилцоогоор авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон судлалын салбарын багш нар холбоотой ажилладаг сургалтын болон бусад байгууллагад оюутан төгсөгчдийг цагийн ажил, тогтмол ажилд зуучилж, ажилд орох үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн байна.

Зөвлөмж:

- ЕБС-ийн багш нарын чанарыг сайжруулахын тулд элсэгчдийн босго оноог илүү өндөр болгох, өндөр оноотой элсэгчдэд үзүүлэх хөнгөлөлт, тэтгэлгийн тогтолцоог илүү боловсронгуй болгох.

ОРОС:

- Тус сургууль нь элсэлтийн бодлого, дүрэм журам, зарыг сургуулийн вэбхуудас, <http://www.mnue.mn> http://burtgel_surgalt.mn цахим хуудсаар дамжуулан түгээдэг. 2014 онд батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын дагуу ЭЕШ-д 650-750 оноотой элсэгч 70%, 751-ээс дээш оноотой элсэгч 100 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэгт хамрагдах болсон нь багшлах авъяас сонирхолтой оюутны тоо нэмэгдэх, оюутан элсүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж элсэлт болон сургалтын чанарт эерэгээр нөлөөлж байна. Элсэлт 2014-2015 оны хичээлийн жилд 48 байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 65 болж 26%-иар өссөн. Гэвч анхаарах зүйл бий нь энэ хугацаанд элсэгчдийн дундаж оноо 572-оос 502 руу буусан нь энэ талаар цаашид анхаарч судалгааг нарийвчлан хийх шаардлагатайг харуулж байна.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлагыг “Оюутны хөгжлийн алба”-ны болон элсэлтийн шалгалтын комисс эрхлэн өгдөг.
- Гадаад оюутан ОХУ, Өвөр Монголоос цөөн тооны /3 оюутан/ оюутан суралцаж төгссөн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Орос хэлний багшийн хэрэгцээ бага боловч нэмэгдэж байгаа.

Анхаарах асуудал:

- Орос хэлний багшийн ангид элсэгчдийн тоо цөөн .

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээг “Оюутны хөгжлийн алба” эрхэлж, цахим ТҮЦ машин, IT сургалтын төв, оюутан бие даан ажиллах өрөөтэй.
- Сар бүрийг нэрэмжит ажил болгон зарлаж оюутанд суралцах, судлах арга зүй, мэргэжил, хөдөлмөр эрхлэлтээр зөвлөн тусладаг.
- Шинэ элсэгч оюутан бүрт Зөвлөх багш томилж, оюутан суралцаж эхлэхээс төгсөх хүртэл сургалтын үйл ажиллагааг явуулахад тусладаг.
- 2016-2019 онд солонгос хэлний 3 багш оюутны эрдэм шинжилгээний хуралд 7 илтгэл удирдан хэлэлцүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- МУБИС-ийн захирлын тушаалаар элсэгч оюутан бүрт Зөвлөх багш томилон ажиллуулдаг, томилогдсон багш нь оюутанд суралцах хугацаанд үйл ажиллагаагаа төлөвлөх, суралцаж эхлэхээс төгсөх хүртэлх хугацаанд сургалтын үйл ажиллагааг явуулахад туслах үүрэгтэй. Эдгээр үүргийг зөвлөх багшид нарийвчлан зааж өгсөн байдаг. Зөвлөх багшийн хариуцсан оюутны тооноос хамааруулан нэг хичээлийн жилд 1-2 кредит цаг тооцдог бөгөөд энэ дагуу тайлангаа зөвлөх багш гаргаж дүгнүүлдэг байна.
- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээг зөвлөх багшаас гадна сургалтын албаны ажилтан, “Оюутны хөгжлийн төв”, оюутанд үйлчлэх төв, эрүүл мэндийн төв, номын сан зэрэг олон талын хамтын ажиллагаагаар суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлж хэвшсэн нь тайлангаас харагдаж байна.
- Эдгээрийн дотор хятад судлалын оюутнуудыг цаг үеийн мэдээ мэдээллэр хангах үйл ажиллагаа зохих ач холбогдолтой, хятад хэлний “Хятад хэлний гүүр” олимпиад, Күнзийн институт, Хятад-Монголын соёлын нийгэмлэгийн үйл ажиллагаанд оюутнуудыг татан оролцуулж байгаа нь мэргэжилд ойртуулах үр дүнтэй, тогтмол хийгддэг ажил болсон байна.
- 2014-2019 онд оюутны эрдэм шинжилгээний хуралд 15 оюутан бэлтгэн оролцуулж батламж, тусгай байр, 3-р байрын шангал авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- МУБИС-ийн захирлын тушаалаар элсэгч оюутан бүрт Зөвлөх багш томилон ажиллуулдаг, томилогдсон багш нь оюутанд суралцах хугацаанд үйл ажиллагаагаа төлөвлөх, суралцаж эхлэхээс төгсөх хүртэлх хугацаанд сургалтын үйл ажиллагааг явуулахад туслах үүрэгтэй. Эдгээр үүргийг зөвлөх багшид нарийвчлан зааж өгсөн байдаг. Зөвлөх багшийн хариуцсан оюутны тооноос хамааруулан нэг хичээлийн жилд 1-2 кредит цаг тооцдог бөгөөд энэ дагуу тайлангаа зөвлөх багш гаргаж дүгнүүлдэг байна.
- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээг зөвлөх багшаас гадна сургалтын албаны япон хэлний хөтөлбөр хариуцсан ажилтан, “Оюутны хөгжлийн төв”, оюутанд үйлчлэх төв, эрүүл мэндийн төв, номын сан зэрэг олон талын хамтын ажиллагаагаар суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлж хэвшсэн нь тайлангаас харагдаж байна.
- Эдгээрийн дотор “Оюутан багш”-ийн оюутан оюутандаа туслах сургалт, мэргэжлийн багш удирддаг дугуйлан, оюутны хөгжил, төлөвшлийг дэмжсэн сургалт семинарууд, хөдөлмөр эрхлэлт, цагийн ажил, сургуулийн урамшуулалт болон бүх төрлийн тэтгэлэг, оюутан солилцоо, эрүүл мэнд, сэтгэл зүйн тулгамдсан асуудал, цаг үеийн мэдээ мэдээллээр хангах үйл ажиллагаа зохих ач холбогдолтой, зөв үр дүнтэй, хариуцсан нэгж эзэнтэй тул тогтмол хийгддэг болсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургууль болон улсын хэмжээнд зохиогддог уран илтгэлийн болон бусад уралдаан тэмцээн, япон хэлний баяр зэрэгт оюутнуудаа тогтмол оролцуулж, зөвлөн туслах ажил хийж ирсэн байна. Хамтын ажиллагаатай Японы их сургуулиудтай оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэхийн сацуу соёлын хичээл зэрэг арга хэмжээ зохион байгуулдаг уламжлалтай болжээ.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн чиглэлээр зохиогдож буй уралдаан тэмцээнд суралцагчдын үзүүлж буй амжилтын талаар хийсэн судалгааны дүн харагдаагүй.

Зөвлөмж:

- Оюутнуудад суралцахуйн сэтгэл судлал, хөгжлийн сэтгэл судлалын чиглэлээр зөвлөгөө чиглүүлэг өгөх багш, мэргэжилтэнтэй болох, энэ чиглэлээр багш нар мэргэших шаардлагатай.

ОРОС:

- Орос хэлний анги бүлэг бүр захирлын шийдвэрээр томилогдсон ангийхаа оюутанд зөвлөлгөө өгөх, тэдний бие даан сурах, төрөл бүрийн ажил зохиоход нь туслалцаа үзүүлэх үүрэг бүхий ангийн зөвлөх багштай байдаг. Багш бүр жилийн ажлын төлөвлөгөөндөө оюутнууддаа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг тусгадаг. Оюутанд үйлчлэх төв, эрүүл мэндийн төв, номын сан, “Оюутны хөгжлийн алба” зэрэг олон нэгжүүд хамтын ажиллагаагаар зөвлөх үйлчилгээг оюутанд үзүүлдэг.
- ОХАЗТ-ийн нэрэмжит спорт өдөрлөг зохион байгуулах, “Номын баяр”, “Монгол наадгай” өдөрлөг, “Мэргэжил сурталчлах” өдөрлөг, “Мөнгөн үдэш - 2019” өдөрлөг, “Өөрчлөлтийг өөрөөс эхлээ” аян, Монгол-Зөвлөлтийн дайчдын ялалтад зориулсан ойн баярын өдөрлөг зэрэг тогтмолжсон арга хэмжээг оюутны дунд зохион байгуулж хэвшсэн.
- Жил бүр оюутны эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг, тухайлбал, “Миний мэргэжил-гадаад хэлний багш-2019” ОЭШ-ний хурал, “Судлаач оюутан-2019” хуралд оюутнууд идэвхтэй оролцсон. Сургуулийн зүгээс <http://www.pnas.org>, <http://www.spiedigitallibrary.org>, <http://link.springer.com/>, <http://istor.org/>, <http://journals.sagepub.com> зэрэг мэргэжлийн сэтгүүлд хандах эрхийг багш оюутанд нээж өгсөн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Сургалтын төлбөр тооцооны журамд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх болзлуудыг тодорхой тусгаж өгсөн.
- БНСУ-ын Засгийн газрын тэтгэлэг, Намьяанжү сангийн тэтгэлэг зэрэгт хамрагддаг.
- 2014-2019 онд сайн дурын сургалт, нийгмийн тустай хөдөлмөр 13 удаа зохион байгуулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Тэтгэлгийн төрлийг нэмэгдүүлэх;
- Оюутны Эрдэм шинжилгээний ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх

ХЯТАД:

- Оюутны бие даан болон хамтран суралцах үйл ажиллагааг төлөвшүүлэх, сургалтын таатай орчинг сайжруулахад чиглэсэн 24 Клубийн ажил тогтмолжсон. Оюутнууд мэтгэлцээний урлагийн “Эдос” клуб зэрэг нийт оюутныг хамарсан клубийн зэрэгцээ “Хятад хэлний баяр”, казак оюутнуудын “Нур Алем” клубийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байна.
- Клубийн үйл ажиллагааг кредит урамшууллын дагуу урамшуулдаг, харин оюутнууд өөрсдийн идэвх сонирхолын дагуу олон нийтийн байгууллага, Клубийн ажилд оролцдог, зөвлөх багш энэ тухай төгсөгчийн тодорхойлолт гаргадаг.
- Оюутанд цагийн ажилд зуучлах НХУС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр оюутнууд зуучлуулдаг.
- Хятад хэлний оюутнуудын дунд цаасан хайчилбарын тэмцээн, уран бичлэгийн уралдаан зэрэг ажил, мэргэжлийн онцлог тусгасан уралдаан тэмцээн явуулж шалгарсан оюутныг урамшуулдаг.
- Хятад хэлний оюутнууд их сургуулийн хэмжээний 20 гаруй байгууллагын тэтгэмжээс гадна Күнзийн институт жил бүр шалгарсан 5-7 оюутанд тэтгэлэг олгодог ба Зүүн хойдын Багшийн их сургуульд хэлний дадлага бүтэн жилээр хийх зэргээр 2015-2019 оны хооронд нийт 237 оюутан тэтгэлэгт хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Оюутны бие даан болон хамтран суралцах үйл ажиллагааг төлөвшүүлэх, сургалтын таатай орчинг сайжруулахад чиглэсэн “Харах өнцөг” клуб, “Марко Поло” клуб, “Утга зохиол нэгдэл” клуб, “Төгс аялагч” клуб, мэтгэлцээний урлагийн “Эдос” клуб зэрэг нийт оюутныг хамрасан Клубийн зэрэгцээ “Япон хэл дээр уншлага”, казак оюутнуудын “Нур Алем” Клубийн үйл ажиллагаанд япон хэлээр сурч буй оюутнууд тогтмол хамрагдаж байна.
- Клубийн үйл ажиллагааг кредит урамшууллын дагуу урамшуулдаг, харин оюутнууд өөрсдийн идэвхи сонирхолын дагуу олон нийтийн байгууллага, Клубийн ажилд оролцдог, зөвлөх багш энэ тухай төгсөгчийн тодорхойлолт гаргадаг.

- Оюутанд цагийн ажилд зуучлах НХУС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн зохицуулагчаар 3-р курсын оюутан ажилладаг.
- 2018-2019 оны хичээлийн жилд япон хэлний багшийн 3 дугаар курсын оюутан Б.Иш нь Японы Элчин сайдын яам, Монгол-Япон төв, Монголын япон хэлний багш нарын холбооноос зохион байгуулдаг “Япон хэлээр хэн сайн уран илтгэх вэ?” тэмцээнд 2-р байр эзлэн Японд аялах эрхээр шагнуулсан. Жил бүрийн 12 сард Монголд зохион байгуулагддаг “Япон хэлний түвшин тогтоох шалгалт”-ад оюутнаа хичээлээс гадуур зөвлөгөө өгч бэлтгэн оруулдаг.
- Япон хэлний оюутнууд их сургуулийн хэмжээний 20 гаруй байгууллагын тэтгэмжээс гадна хэлний салбарын дотроо сүүлийн таван жилийн судалгаанаас үзвэл давхардсан тоогоор өндөр онооны тэтгэлэгт 16, оюутны хөгжлийн зээлд 8, япон улсад оюутнаар сурах тэтгэлэгт 24 оюутан тус тус хамрагдсан ба үүний зэрэгцээ буцалтгүй тусламжийг 21 оюутан, бусад байгууллагын тэтгэлгийг 2 оюутан авчээ. Япон хэлний оюутнуудад нэг жилийн жилийн тэтгэлэгт хөтөлбөрийг: Акита их сургууль, Азийн их сургууль, Хёого Боловсролын их сургууль, Айчи их сургууль тус бүр 1-3 оюутанд олгох боломжтойн дээр Япон улсын Засгийн газрын тэтгэлгээр Япон хэл, соёл судлаач оюутны хөтөлбөр, Японы Боловсрол, Шинжлэх Ухааны Яамнаас хэрэгжүүлдэг 6 төрлийн хөтөлбөрт тэтгэлгээр сурах боломжтой.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Японы Элчин сайдын яам, Монгол-Япон төв, Монголын япон хэлний багш нарын холбооноос зохион байгуулдаг “Япон хэлээр хэн сайн уран илтгэх вэ?” тэмцээн, жил бүрийн зохион байгуулагддаг “Япон хэлний түвшин тогтоох шалгалт”-д багш нар оюутнуудыг хичээлээс гадуур зөвлөгөө өгч бэлтгэн оруулдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааны судалгаа хийгдээгүй.

Зөвлөмж:

- Оюутны сайн дурын үйл ажиллагаа, ялангуяа мэргэжлийн чиглэлтэй уялдаж болохуйц үйл ажиллагааг дэмжих, чиглүүлэх.

ОРОС:

- Орос хэлний багшийн мэргэжлийн оюутны дунд “Клуб будущих учителей” байгуулж гурав дахь жилдээ ажиллаж байна. Үүний зэрэгцээ “Залуу заах

аргачдын клуб”, “Мэдрэмж” бүжгийн дугуйлан, “Уран нүүдэл” даамны клуб –т нийт 40-50 оюутан хамрагддаг. ОХАЗТ-ийн оюутнууд 2016-2019 оны хооронд 6 эрдэм шинжилгээний хуралд 10 судалгааны ажил хэлэлцүүлсэн. “Төгсөгчдөд баяр хүргэх үйл ажиллагаа”, “Ялалтын баяр”, спортын өдөрлөг зэрэг тогмолжсон олон үйл ажиллагаанд оюутнууд идэвхитэй оролцдог.

- МУБИС-ийн Захирлын А/186 тоот тушаалаар батлагдсан “Оюутны журам”-аар оюутны сурах, хөгжих үйл ажиллагааг зохион байгуулах, урамшуулах, тэтгэлэгт хамруулах асуудлыг зохицуулдаг. Улиралд нэг удаа оюутанд үйлчлэх албаны тодорхойлолтоор сайн дурын болон мэргэжлийн Клубийн ахлагчид 1 хүртэл кредит, клубт хичээл заадаг оюутан бүрт нэг хүртэл кредитийн тэтгэлэг олгож урамшуулдаг. 2019 онд шинэчлэгдсэн төлөвлөгөөгөөр сайн дурын 2 кредитийн ажлыг бүх курстээ дадлагын хэлбэрээр гүйцэргэхээр болсон.
- Сүүлийн 5 жилд “Орос хэлний багш” хөтөлбөрөөр 200 оюутан төгссөнөөс 92 төгсөгч буюу 46% нь мэргэжлээрээ ажиллаж байна. Оюутанд цагийн ажилд зуучлах НХУС-ийн Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн зохицуулагчаар 3-р курсын оюутан ажилладаг.
- Оюутан дараагийн улиралд сонгосон үндсэн мэргэжлийн хичээлүүдийн сургалтын төлбөр төлөхдөө хуримтлуулсан голч дүн нь 2 улирал дараалан 3,7-оос дээш бол 2 кредит, 3 улирал дараалан 3,7-оос дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан бол 4 кредит тэтгэлэг урамшуулалд хамруулдаг. “Орос хэлний багш” хөтөлбөрийн оюутнуудаас 2014-2019 онд нийт төгсөгчдийн 46 нь сургалтын төлбөрийн 70%, 16 оюутан нь 100%-ийн хөнгөлөлт эдэлсэн. Оюутны хөгжлийн зээлийн тэтгэлэг 16 оюутан, төрийн буцалтгүй тусламжаар 63 оюутан тэтгэлэгт хамрагдсан. “Зориг сан”, “Дэлхийн зөн”, “Bank of China”, Эрдэнэт үйлдвэр, ХААН болон Голомт банкны тэтгэлэгт тус бүр 1 оюутан хамрагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2019 онд шинэчлэгдсэн төлөвлөгөөгөөр сайн дурын 2 кредитийн ажлыг бүх оюутан дадлагын хэлбэрээр гүйцэтгэхээр болсон.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- 2014-2019 онд солонгос хэлний ангийн 56 оюутан шилжсэн бөгөөд үүнээс 14,3 хувь нь сургууль дотроо болон их дээд сургууль хооронд шилжсэн.
- Сургууль хооронд шилжихэд дүйцүүлсэн кредитийн зөрүү 15-аас ихгүй байна.
- Шилжиж буй суралцагч 30-50 хувийн төлбөрийг тухайн улирлын төлбөрөөс гадна төлдөг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Шилжин ирж суралцаж буй оюутнаас тухайн улирлын төлбөрөөс гадна авдаг 30-50 хувийн төлбөрийн зориулалт, үндсэн хууль, бусад холбогдох хуулийн зүйл ангитай уялдаж буй эсэхийг анхаарах.

ХЯТАД:

- Сүүлийн 5 жилд хятад хэлний салбарын суралцагчдаас 176 оюутан шилжилт хөдөлгөөнд хамрагдсанаас, 40 оюутан жилийн чөлөөнөөс үргэлжлүүлэн суралцахаар ирж суралцсан, жилийн чөлөө авсан 107 байна. Шилжилт хөдөлгөөний зонхилох хувийг жилийн чөлөө эзэлжээ. 2018-2019 оны хичээлийн жилд шилжин ирж буй 10, шилжин явж буй оюутан 19 байна. Сурч байгаа 67 оюутнаас ар гэрийн шалтгаанаар 4, эрүүл мэндээр 2 оюутан сургуулиас гарч бусад их дээд сургууль руу шилжсэн 5 оюутан байна.
- Оюутны шилжилт хөдөлгөөнд кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэрэгт үйлчилдэг дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Сүүлийн 5 жилд япон хэлний салбарын суралцагчдаас 3 оюутан сургуулиас гарсан, 3 оюутан шилжсэн, 44 оюутан жилийн чөлөөнөөс үргэлжлүүлэн суралцахаас 25 оюутан ирж суралцсан байна. Үүнээс үзвэл шилжилт хөдөлгөөний зонхилох хувийг ар гэрийн болон хувийн гачигдал эзэлжээ. 2018-2019 оны хичээлийн жилд сурч байгаа 35 оюутнаас оюутны хөдөлгөөнд 16 оюутан орсон байгаа нь анхаарал татаж байгаа боловч үндсэн шалтгаан нь жилийн чөлөө авалт буюу 10 оюутан байна. Мөн бүрэлдэхүүний сургуулиас

3 оюутан шилжиж иржээ. Оюутны шилжилт хөдөлгөөнд кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх зэрэгт үйлчилдэг дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны шилжилт хөдөлгөөний зонхилох хувийг ар гэрийн болон хувийн гачигдал эзэлдэг.

Анхаарах асуудал:

- Оюутны шилжилт хөдөлгөөн харьцангуй их байдаг тул элсэгч төгсөгчдийн харьцаа алдагдсан.

Зөвлөмж:

- Сурлагын амжилтаас шалтгаалсан оюутны шилжилт хөдөлгөөнийг зүй зохистой шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

ОРОС:

- Орос хэлний багш мэргэжлийн оюутнуудаас 2014-2019 онд 119 оюутан шилжилт хөдөлгөөнд хамрагдсаны 92 нь жилийн чөлөө авсан болон чөлөөнөөс ирсэн оюутан (77,3%) эзэлж байна. Бусад их дээд сургуулиас шилжиж ирсэн оюутан 14 байгаа нь нийт хөдөлгөөний 11,7%-ийг эзэлж байна. Мөн бусад их дээд сургуульд 3 оюутан шилжсэн байна. МУБИС дотроо 10 оюутан (8,4%) шилжиж иржээ.
- Сургуулиас гарч буй оюутан сүүлийн 5 жилд 33 байгаагаас ар гэрийн шалтгаантай 16 (48,4%), гадаад явсан 8, бусад их дээд сургууль руу шилжсэн 6 (18,2%) байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос шилжилт хөдөлгөөн багасч хөтөлбөрийн хэрэгжилт тогтворжиж байгаа.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Бакалаврын зэргээр төгсөх оюутны ерөнхий голч дүн 1,7-оос доошгүй үед мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн диплом, энгэрийн тэмдэг зохих журмын дагуу олгодог.
- Төгсөлтийн салбар комисс төгсөгчийн талаар зохих журмын үндсэн долоон шаардлагыг хангасан баримт бичгийг архивт бүрдүүлж хадгалуулдаг.
- Голч дүн 1,7-оос доош үед, эсвэл нэгдсэн (ахицын) үнэлгээг хангалттай авч чадаагүй оюутанд уг нөхцөлийг хангах боломж олгох ба хэрэв оюутан хүсвэл заасан бүх хичээлийг судалсаныг гэрчилсэн үнэмлэх олгох журамтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Бакалаврын зэргээр төгсөх оюутны ерөнхий голч дүн 1,7-оос доошгүй үед мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг-дипломыг англи-монгол бичиг-кирилл гурван хэлбэрээр хэвлэж, энгэрийн тэмдэг олгодог байна. Төгсөлтийн салбар комисс төгсөгчийн талаар зохих журмын үндсэн долоон шаардлагыг хангасан баримт бичгийг архивт бүрдүүлж хадгалуулдаг.
- 2014-2019 онд хятад хэлний багш хөтөлбөрөөр нийт 182 оюутан төгссөнөөс эрэгтэй 12 төгсөгч байна
- Голч дүн 1,7-оос доош үед, эсвэл нэгдсэн (ахицын) үнэлгээг хангалттай авч чадаагүй оюутанд уг нөхцөлийг хангах боломж олгох ба хэрэв оюутан хүсвэл заасан бүх хичээлийг судалсаныг гэрчилсэн үнэмлэх олгох журамтай.
- Төгсөлтийн ажиллагааг “Эрдмийн баяр” ёслол хүндэтгэлийн арга хэмжээ болгон зохион байгуулж шилдэг оюутныг шагнах, шинээр ажил олгогч аж ахуйн нэгжүүдийг урин ажилд орж буй оюутнуудтай хөдөлмөрийн гэрээг үзэглэх ажил зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Бакалаврын зэргээр төгсөх оюутны ерөнхий голч дүн 1,7-оос доошгүй үед мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг-дипломыг англи-монгол бичиг -кирилл гурван хэлбэрээр хэвлэж, энгэрийн тэмдэг олгодог байна. Төгсөлтийн салбар комисс төгсөгчийн талаар зохих

журмын үндсэн долоон шаардлагыг хангасан баримт бичгийг архивт бүрдүүлж хадгалуулдаг.

- 2014-2019 онд япон хэлний багш хөтөлбөрөөр нийт 62 оюутан төгссөнөөс эрэгтэй 2 төгсөгч байна
- Голч дүн 1,7-оос доош үед, эсвэл нэгдсэн (ахицын) үнэлгээг хангалттай авч чадаагүй оюутанд уг нөхцлийг хангах боломж олгох ба хэрэв оюутан хүсвэл заасан бүх хичээлийг судалсныг гэрчилсэн үнэмлэх олгох журамтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн таван жилд япон хэлний багш хөтөлбөрөөр нийт 62 оюутан төгссөнөөс эрэгтэй 2 төгсөгч байна.

Анхаарах асуудал:

- Хавсарга мэргэжлээр суралцсан оюутны талаарх мэдээлэл тусгагдаагүй.

Зөвлөмж:

- Хавсарга мэргэжлээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

ОРОС:

- Бакалаврын зэргээр төгсөх оюутны ерөнхий голч дүн 1,7-оос доошгүй үед мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг-диплом, энгэрийн тэмдэг олгодог байна. Төгсөлтийн салбар комисс төгсөгчийн талаар зохих журмын дагуу шаардлага хангасан баримт бичгийг архивт бүрдүүлж хадгалуулдаг.
- 2014-2019 онд орос хэлний багш хөтөлбөрөөр нийт 219 оюутан төгссөн.
- Голч дүн 1,7-оос доош үед, эсвэл нэгдсэн (ахицын) үнэлгээг хангалттай авч чадаагүй оюутанд уг нөхцөлийг хангах боломж олгох ба хэрэв оюутан хүсвэл заасан бүх хичээлийг судалсаныг гэрчилсэн үнэмлэх олгох журамтай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Солонгос: 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Хятад хэл: 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан
Япон хэл: 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Орос хэл: 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- МУБИС-ийн “Багшийн ажиллах журам”-д багшийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай журамласан. Шинэ багшийг 6 үе шаттай сонгон шалгаруулж авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшлах боловсон хүчнийг зөвхөн МУБИС төгсөгчдөөс сонгон ажиллуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хариуцагч багш нар багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байдлын судалгаа хийх;

Зөвлөмж:

- Хөтөлбөр хариуцсан монгол багш нар докторын зэрэг хамгаалах;

Хятад:

- Хөтөлбөрийн зорилгод нийцсэн багш сонгон шалгаруулах дүрэм, журмуудыг шинэчлэн баталсаар ирсэн.
- 2015-2016 оны хичээлийн жил хүний нөөцийг хөгжүүлэх зорилго бодлого баримталж ажиллаж эхэлсэн.
- Багшийг 6 үе шаттайгаар сонгон шалгаруулж авдаг.

- Багшийн хөгжил, чадамжийн түвшинг илэрхийлсэн албан тушаалын зэрэглэлийг тодорхойлж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг.
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулах тогтолцоо хэрэгждэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувь бага.
- Үндсэн багш цөөн. Гэрээт цагийн багш нь үндсэн багшаасаа олон. Сургалын чанарын асуудал хөндөгдөхөөр харагдаж байна.
- Багш, суралцагчдын тоон харьцаа зохисгүй /2016-2017-1:54, 2017-2018-1:49, 2018-2019 1:60/ байна. Нэг багшид оногдох оюутны тоо хэтэрсэн байна.

Япон:

- МУБИС-ийн хэмжээнд дагаж мөрддөг “Багшийн хөгжлийн хөтөлбөр”/2019-2024/ байдаг ба түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Сургалтын хөтөлбөр, багшийн хөгжлийн албатай. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж МУБИС-ийн “Багшийн ажиллах журам”-д үндэслэн багшийн сонгон шалгаруулалтыг хийдэг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг нь 4 магистр багшийн бүрэлдэхүүнтэй, 14-19 жилийн ажлын туршлагатай, бүгдээрээ докторатурт суралцаж буй, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь хангалтгүй байна.
- Оюутны тоо харьцангуй цөөн тул багш оюутны тооны харьцаа зохимжтой, багш нарын хувьд оюутантай тулж ажиллахад боломжтой.
- Багшлах бүрэлдэхүүний 2 нь багш, 2 нь ахлах багшийн албан тушаалын зэрэглэлд ажилладаг.
- Багш нар жил бүр багшлах болон бусад ажлын хувийн төлөвлөгөө гаргаж ажилладаг, үүний хэрэгжилтийн дагуу цагийн ноогдлын биелэлт болон бусад ажлаа үнэлүүлж дүгнүүлж хэвшсэн.
- МУБИС-ийн хэмжээнд зохих журмын дагуу багш нарт үр дүнгийн урамшуулал олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч баг нь 4 магистр багшийн бүрэлдэхүүнтэй, 14-19 жилийн ажлын туршлагатай, мэргэжлийн ур чадвартай, бүгдээрээ

докторатурт суралцаж буй, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь хангалтгүй байна.

Анхаарах асуудал:

- Багш нар 14-19 жил ажиллаж байгаа ч докторын зэргээ хамгаалаагүй байгаа.

Зөвлөмж:

- Тодорхой бодлого, төлөвлөгөөний дагуу ойрын жилүүдэд докторын зэрэг хамгаалах багш нарыг тоог нэмэгдүүлэх.

Орос:

- Хэл шинжлэл, орос хэл заах арга зүйн чиглэлээр нарийн мэргэшсэн чадварлаг боловсон хүчнийг сонгон авч ажиллуулах, өөрийн тэнхимийн шилдэг сайн төгсөгчдийг онгон авч магистр, докторын түвшинд сургалт, судалгаа, арга зүйн зөвлөгөө өгч, улмаар эрдэм судлалын ажлыг чиглүүлж, дэмжих замаар залуу халаагаа бэлтгэх тэнхимийн уламжлалт хүний нөөцийн бодлого хэрэгжүүлж ирсэн. Нийт 6 багшийн 5 нь докторын зэрэгтэй. 2 багш тэнхимийн хариуцсан хөтөлбөрөөр суралцаж төгссөн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын 83,3% докторын зэрэгтэй, 66,7% эрдмийн цолтой.

Зөвлөмж:

- Гэрээгээр болон багш солилцоо, бусад хэлбэрээр ОХУ-ын их дээд сургуулиас орос хэлний багш авч ажиллуулах

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан тоон судалгаа гаргасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Хятад:

- МУБИС-ийн захирлын 2018 оны А-249 тоот тушаалаар Багшийн хөгжлийн хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн. Багшийн багшлахуйн болон судлан шинжлэх үйл ажиллагаандаа шинэ туршлага нэвтрүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлөө хангах тогтолцоог нэвтрүүлэн багшийн чанарыг олон улсын жишигт хүргэх үйл ажиллагааг гол чиглэл болдог.
- Тайлант хугацаанд 3 багш, ажилтан гадаад дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд оролцсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Япон:

- Багшийн хөгжилтэй холбоотой судалгаа 2019 оны 5 сард хийгдсэн хэдий ч үр дүн нь нийтлэгдээгүй тул эргэх холбоо хангагдаагүй байна.
- Багш нар хичээлийн жилийн эхэнд ажлын төлөвлөгөө хийж, жилийн эцэст тайлангаа гаргадаг.
- Тайлант хугацаанд багш нарын 50 хувь нь Япон улсад мэргэжлийн чиглэлээр, 75 хувь нь дотоодын сургалт, семинар, симпозиумд мэргэжил дээшлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар мэргэжлийн чиглэлээр зохиогддог хурал, семинар, сургалтанд зохих хэмжээнд оролцож ирсэн.

Анхаарах асуудал:

- Тайлант хугацаанд багш нарын 50 хувь нь Япон улсад мэргэжлийн чиглэлээр, 75 хувь нь дотоодын сургалт, семинар, симпозиумд мэргэжил дээшлүүлсэн нь хангалттай бус байна.

Зөвлөмж:

- Тодорхой бодлого төлөвлөгөөний дагуу багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, сайжруулах.

Орос:

- Багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол

явуулсны дүнд багшийн хөгжлийн асуудлуудыг шийддэг. Тэнхимийн үйл ажиллагааны нэг, гурван жилийн төлөвлөгөө, багш бүр өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр улирал, жил, гурван жилээр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэг. Тухайлбал, ОХУ-ын ЭСЯ болон Оросын ШУСТ-өөс явуулдаг орос хэлний сургалт, семинарт багш нар 100% хамрагддаг. Монголын орос хэл, уран зохиолын багш нарын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Багш нарын гадаад дотоодод орос хэлний сургалтын туршлага судлах талаар анхаарах.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- МУБИС-ийн эрдэм шинжилгээний ажлыг хөгжүүлэх хөтөлбөр /2013-2018/
- МУБИС-ийн эрдэм шинжилгээний оюуны өмчийн талаар баримтлах бодлого
- Оюуны өмчийг бүртгэх, хадгалах, ашиглах, эзэмших журам
- Хөтөлбөр хариуцагч багш нарын гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын жагсаалт
- Багшийн гадаад, дотоодын ЭШХ-д оролцох зардлын тодорхой хувийг захирлын тушаалаар санхүүжүүлэн дэмждэг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хариуцагч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээр оюуны өмчийн эрх, инноваци, ашигтай загвар, патент авах
- Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, үнэлгээ хийх.

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээний бүтээл, судалгааны ажлыг эрчимжүүлэх, эшлэгдсэн байдлыг дэмжихэд чиглэсэн профессорын манлайллыг дэмжин ажиллах
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэхэд гадаад, дотоодын хамтын ажиллагаатай байгууллагуудтай хамтран ажиллах, төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллах.
- Багш нарын судалгааг ОУ-ын фактор өндөртэй сэтгүүлд хэвлүүлэх тал дээр анхаарч, дэмжин, фактор өндөртэй сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлэх сургалт явуулах

Хятад:

- Тайлант хугацаанд хөтөлбөрийн багш нар дотооддоо 5 удаа багш нарын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан.
- Тайлант хугацаанд Зүүн хойдын багшийн их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн.
- Дотоодод ЭШХ дээр илтгэл хэлэлцүүлэх, дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлэх, шилдэг өгүүллийг орчуулах зэрэг эрдэм шинжилгээний өгүүллийн тоо өссөн.
- Тайлант хугацаанд эрдэм шинжилгээний зардал өссөн.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулиас эрдэм шинжилгээний ажлуудыг дэмжсэн олон бодлогыг хэрэгжүүлдэг.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патентийн тоон судалгаа огт байхгүй.
- Гадаадын судалгааны сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо цөөн.
- Хэрэгжүүлсэн төсөл байхгүй.
- Зарцуулсан төсөв, тайлан байхгүй.
- Судалгааны ажлаас эшлэгдсэн тоон үзүүлэлт байхгүй.

Япон:

- Салбарын багш нар “Багш мэргэжлийн стандарт”-ыг боловсруулах ажилд оролцсон. Япон хэлний боловсролын JF стандартын үзэл баримтлал, агуулгыг зарим хичээлд тусгах, түүнчлэн “хамтран суралцахуйн аргазүй”-г сургалтанд нэвтрүүлэх ажлыг хийж байгаа.
- “МУБИС-ийн эрдэм шинжилгэний ажлыг хөгжүүлэх хөтөлбөр”/2013-2018/, “МУБИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн журам”, “МУБИС-ийн хөгжлийн бодлого”/2019-2024/ зэрэг бодлогын баримт бичгүүдийг мөрдөж ажилладаг.
- Сүүлийн 5 жилд багш нар гадаадын санхүүжилттэй 7 төсөл, дотоодын санхүүжилттэй 1 төсөлд оролцож ажилласан байна.
- Тайлант хугацаанд багш нар 7 сурах бичиг, гарын авлага хэвлүүлж, 16 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, 19 илтгэл хэлэлцүүлсэн байна.
- Эрдэм шинжилгээний хуралд оролцох зардлын тодорхой хувийг бүрэлдэхүүн сургуулиас санхүүжүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн 5 жилд багш нар гадаадын санхүүжилттэй 7 төсөл, дотоодын санхүүжилттэй 1 төсөлд оролцож ажилласан нь хангалттай үзүүлэлт байна.
- Тайлант хугацаанд багш нар 7 сурах бичиг, гарын авлага хэвлүүлж, 16 эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлж, 19 илтгэл хэлэлцүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Гадаадын мэргэжлийн холбоодын гишүүн болсон багшийн тоо цөөн.
- Багш нар сургуулийнхаа зүгээс судалгаа шинжилгээний ажил хийхэд зориулсан санхүүгийн дэмжлэг авч үзээгүй.

Зөвлөмж:

- Бүх багш нар гадаадын мэргэжлийн холбоодод гишүүнчлэлтэй болох.
- Гадаад дотоодын мэргэжлийн сэтгүүл, чансаа өндөртэй мэргэжлийн сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
- Багш нар мэргэжлийн чиглэлийн дагуу сурах бичиг, гарын авлага зохиох, хэвлүүлэх ажлыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Орос:

- Тэнхимийн багш нарын гүйцэтгэсэн төсөл хөтөлбөр, гүйцэтгэсэн гэрээт ажил, дотоодод зохион байгуулсан сургалт семинар, гадаад, дотоодын

нэр хүндтэй хэвлэлд хэвлэгдсэн багш нарын бүтээл, эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл, хэвлүүлсэн бүтээлийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын төсөв, зардлын хэмжээгээр багш нарын эрдэм судлалын ажил тодорхойлогдож байна.

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг урьдаас төсөв зохиолгүй шууд зардал гаргадаг байдлаар тайланд орсныг анхаарах хэрэгтэй. /102-р хуудас/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

Солонгос:

- МУБИС-ийн багшийн ажиллах журмын 5.2-д Багшийн ажлыг үнэлж дүгнэх зарчмыг тодорхой тусгасан.
- МУБИС-ийн чанарын баталгаажуулал, мониторингийн албанаас 2 жил нэг удаа тухайн багшийн ахиц дэвшил, багшид тавих шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Гадаадын хамтын ажиллагаатай байгууллагуудад багшийн мэргэжил, заах арга зүй, ур чадвар, судалгааны чадварыг нэмэгдүүлэх зорилгоор туршлага судлуулах бодит боломжоо нэмэгдүүлэх

Хятад:

- Багш бүр хичээлийн жилийн эхэнд сургалт, заах аргазүй, эрдэм шинжилгээ, үйлчилгээ, мэргэжлийн хөгжил гэсэн чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөө боловсруулж, тэнхимийн эрхлэгч, салбар сургуулийн захирлаар батлуулж, мөрдөн ажилладаг.
- Жил бүр өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийдэг.

- Улирал бүр суралцагчдаас хөтөлбөрийн агуулгын судалгаа, багшийн ур чадварын судалгаа, багшийн харилцаа, ёс зүйн судалгаа авч, үр дүнг Мэдээллийн технологийн албанаас багш тус бүрээр нарийвчлан гаргаж тэнхимд нь хүргүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Багшлах боловсон хүчнээ нэмж, багш нарын сургалтын цагийн ачааллыг багасгаж, эрдэм шинжилгээ, судалгаа хийх боломж бололцоогоор хангаж өгөх.

Япон:

- МУБИС-ийн багшийн ажиллах журмын 5.2-т заасан журмын дагуу багш нар тухайн хичээлийн жилд гүйцэтгэсэн ажлын тайлангаа бичдэг.
- Багш нар өөрийн үнэлгээний тайлангаа жилд 3 удаа хэлэлцүүлж, ажлаа үнэлүүлж дүгнүүлж хэвшсэн.
- МУБИС-ийн багшийн ажиллах журмын 5.2.7-гийн дагуу оюутнууд багшийн хичээлийн агуулга, чанар, заах арга, ёс зүй, харилцаа, суралцах орчны талаар үнэлгээг онлайнаар өгдөг. Оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар 60 болон түүнээс доогуур үнэлгээ 2 удаа авсан багшид зохих арга хэмжээ авдаг. Япон хэлний багш нарын хувьд оюутны үнэлгээ сүүлийн 4 жилийн дундаж нь 87 оноо байсан нь хангалттай сайн үзүүлэлт байна.
- 2014 оноос хойш багшийн бичиг баримтын дийлэнх нь цахим хэлбэрт шилжсэн ба холбогдох бүх бичиг баримтыг цахим хэлбэрээр ашиглаж хадгалж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Япон хэлний багш нарын хувьд оюутны үнэлгээ сүүлийн 4 жилийн дундаж нь 87 оноо байсан нь хангалттай сайн үзүүлэлт байна.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны нарийвчилсан дүн шинжилгээ ажиглагдаагүй.

Зөвлөмж:

- Жил бүр оюутны сэтгэл ханамжийн судалгааны нарийвчилсан дүн шинжилгээ хийж, ажилдаа тусгаж хэвших.

Орос:

- Багшийн өөрийн үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээний схем, график, үнэлэлт дүгнэлт шалгуур үзүүлэлтийн дагуу тайланд туссан байна. Хангалттай, нэмэлт санал байхгүй

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Солонгос: 6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Хятад хэл: 6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Япон хэл: 6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Орос хэл: 6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- 2014 онд МУБИС-ийн “Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба” байгуулагдсан.
- 2017 оноос “Хяналт, үнэлгээний алба”-ыг 2019 онд шинэчлэн “Чанарын баталгаажуулалт, хяналт үнэлгээний алба”-ыг байгуулсан.
- МУБИС-ын сургалтын журам /2015 он/, Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам /2018 он/ тус тус батлан мөрдөж ирсэн.
- Багш бэлтгэх бакалаврын хөтөлбөрийн боловсруулалт болон хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээр 7 төрөл ажлаар сургалтын бодит үр дүнг хэмждэг.
- Чанарын баталгаажуулалтаар Багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрөөр 9 гишүүнтэй хөтөлбөрийн дэд хороо ажиллаж байна.

- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, хичээлийн стандарт, хөтөлбөр, оюутныг үнэлэхэд "Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба" хөндлөнгийн магадлах комисс байгуулан үнэлгээ хийдэг.
- Хөтөлбөрийн оролцогч талууд, багш, оюутан, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаанд жил бүр хяналт, шинжилгээ хийж гарсан зөрчил дутагдлыг тухай бүр засаж эрсдэлийг бууруулах, оюутнуудаас хичээлийн жилд 2 удаа судалсан хичээлээр сэтгэл ханамжийн судалгаа авч шинжилгээ хийн хөтөлбөр сайжруулалтад ашиглах, багшаас сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн ур чадвар ёс зүй, сургалтын орчин зэргийн талаар 7-9 төрлийн үнэлгээний судалгаа авч шинжилгээний үр дүнг ажилдаа тусган холбогдох өөрчлөлт засвар оруулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог 2012 оноос нэвтрүүлж эхэлсэн ажлын хүрээнд МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024 он/-д үнэлгээний шалгуур боловсруулах ажил хийгдэж МУБИС-ийн Дотоод журмаар Хяналт, үнэлгээний албыг шинэчлэн байгуулсан. Үүний зэрэгцээ МУБИС-ын сургалтын журам /2015 он/, Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам /2018 он/ тус тус батлан мөрдөж иржээ. НХУС-ийн дэргэд гадаад хэлний багш бэлтгэх бакалаврын хөтөлбөрийн боловсруулалт болон хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээр сургалтын бодит үр дүнг хэмжиж байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт хийхэд Багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрөөр 9 дэд гишүүнтэй хөтөлбөрийн дэд хороо ажиллаж байна. Багш нар хөтөлбөрийн агуулгын давхацлыг арилгах, багц хичээлүүдийн харьцааг нягтлах, багш мэргэжлийн дадлагын цагийн багтаамж, зорилт агуулгыг сайжруулах талаар сүүлийн хоёр хичээлийн жил ажиллаж байна.
- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, хичээлийн стандарт, хөтөлбөр, оюутныг үнэлэхэд "Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба" хөндлөнгийн магадлах комисс байгуулан үнэлгээ хийж түүний явц, үр дүнгийн талаар талаар тайлан гаргаж танилцуулдаг. Мөн багш хичээлийн стандарт, хөтөлбөрөө боловсруулан тэнхимийн хурал, НХУС-ийн хөтөлбөрийн дэд хороо – НХУС-ийн салбар хороогоор хэлэлцүүлж МУБИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн хороогоор батлуулдаг.
- Хөтөлбөрийн оролцогч талууд, багш, оюутан, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаанд жил бүр хяналт, шинжилгээ хийж гарсан зөрчил дутагдлыг тухай бүр засаж эрсдэлийг бууруулах, оюутнуудаас хичээлийн жилд 2 удаа

судалсан хичээлээр сэтгэл ханамжийн судалгаа авч шинжилгээ хийн хөтөлбөр сайжруулалтад ашиглах, багшаас сургалтын хөтөлбө, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн ур чадвар ёс зүй, сургалтын орчин зэргийн талаар 7-9 төрлийн үнэлгээний судалгаа авч шинжилгээний үр дүнг ажилдаа тусган холбогдох өөрчлөлт засвар оруулдаг. Эдгээр судалгаа нь 71%-91% - ийн үнэлгээ авч байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог 2012 оноос нэвтрүүлж эхэлсэн ажлын хүрээнд МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024 он/-д үнэлгээний шалгуур боловсруулах ажил хийгдэж МУБИС-ийн Дотоод журмаар Хяналт, үнэлгээний албыг шинэчлэн байгуулсан. Үүний зэрэгцээ МУБИС-ийн сургалтын журам /2015 он/, Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам /2018 он/ тус тус батлан мөрдөж иржээ. Япон хэлний багш бэлтгэх бакалаврын хөтөлбөрийн боловсруулалт болон хөтөлбөрийн хэрэгжилт гэсэн 2 бүрэлдэхүүн хэсгээр сургалтын бодит үр дүнг хэмжиж байна. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтаар Багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрөөр 10 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн дэд хороо ажилладаг байна.
- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, хичээлийн стандарт, хөтөлбөр, оюутныг үнэлэхэд "Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба" хөндлөнгийн магадлах комисс байгуулан үнэлгээ хийж түүний явц, үр дүнгийн талаар талаар тайлан гаргаж танилцуулдаг болсон. Мөн багш хичээлийн стандарт, хөтөлбөрөө боловсруулан тэнхимийн хурал, НХУС-ийн хөтөлбөрийн дэд хороо –НХУС-ийн салбар хороогоор хэлэлцүүлж МУБИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн хороогоор батлуулдаг.
- Хөтөлбөрийн оролцогч талууд, багш, оюутан, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаанд жил бүр хяналт, шинжилгээ хийж гарсан зөрчил дутагдлыг тухай бүр засаж эрсдэлийг бууруулах, оюутнуудаас хичээлийн жилд 2 удаа судалсан хичээлээр сэтгэл ханамжийн судалгаа авч шинжилгээ хийн хөтөлбөр сайжруулалтад ашиглах, багшаас сургалтын хөтөлбөр, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн ур чадвар ёс зүй, сургалтын орчин зэргийн талаар 7-9 төрлийн үнэлгээний судалгаа авч шинжилгээний үр дүнг ажилдаа тусган холбогдох өөрчлөлт засвар оруулдаг. Эдгээр судалгаанд 71%-91% - ийн үнэлгээ авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгаанд япон хэлний багш нар тогтмол өндөр үнэлгээ авдаг.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд бодитой тусгасан жишээ, нотолгоо ажиглагдаагүй.

Зөвлөмж:

- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлд бодитой тусгаж ажиллах.

ОРОС:

- Үр дүнд суурилсан боловсролын тогтолцоог 2012 оноос нэвтрүүлж эхэлсэн ажлын хүрээнд МУБИС-ийн хөгжлийн бодлого /2014-2024 он/-д үнэлгээний шалгуур боловсруулах ажил хийгдэж МУБИС-ийн Дотоод журмаар Хяналт, үнэлгээний албыг шинэчлэн байгуулсан. Үүний зэрэгцээ МУБИС-ийн сургалтын журам /2015 он/, Сургалтын хөтөлбөрийн чанарыг үнэлэх журам /2018 он/ тус тус батлан мөрдөж мржээ. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтаар Багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрөөр 10 хүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн дэд хороо ажиллаж байна.
- Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, хичээлийн стандарт, хөтөлбөр, оюутныг үнэлэхэд “Чанарын баталгаажуулалт, мониторингийн алба” хөндлөнгийн магадлах комисс байгуулан үнэлгээ хийж түүний явц, үр дүнгийн талаар талаар тайлан гаргаж танилцуулдаг болсон. Мөн багш хичээлийн стандарт, хөтөлбөрөө боловсруулан тэнхимийн хурал, НХУС-ийн хөтөлбөрийн дэд хороо –НХУС-ийн салбар хороогоор хэлэлцүүлж МУБИС-ийн хөтөлбөрийн нэгдсэн хороогоор батлуулдаг.
- Хөтөлбөрийн оролцогч талууд, багш, оюутан, элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаанд жил бүр хяналт, шинжилгээ хийж, жилд 2 удаа судалсан хичээлээр сэтгэл ханамжийн судалгаа авч шинжилгээ хийн хөтөлбөр сайжруулалтад ашиглах, багшаас сургалтын хөтөлбө, эрдэм шинжилгээний ажил, мэргэжлийн ур чадвар ёс зүй, сургалтын орчин зэргийн талаар үнэлгээний судалгааг шууд ба шууд бус аргаар авч шинжилгээний үр дүнд тулгуурлан ажилдаа холбогдох өөрчлөлт засвар оруулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Солонгос хэлний багш мэргэжлээр 18 удаа элсэлт авч 14 удаагийн төгсөлтөөр 260 мэргэжилтэн багш бэлтгэсэн.
- 2015-2019 онд төгсөгчдийн 47,2 хувь нь мэргэжлээрээ ажиллаж 29,9% нь үргэлжлүүлэн сурч, 14,5% нь төрийн захиргаа, хувийн секторт мэргэжлийн бус ажилд, 10,9% ажил эрхлээгүй байна.
- 2018 оноос элсэлт авах тогтолцоог өөрчилж, шууд мэргэжлээр нь авах болсонтой уялдан төгсөгчдийн голч оноо өсөх хандлагатай болсон.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ХЯТАД:

- 2014-2019 онд хятад хэлний багш хөтөлбөрөөр нийт 182 оюутан төгссөн. Хятад хэлийг сонгон суралцагчдын тоо 10000 хүрсэн нь багш мэргэжлээр төгсөгчдийн эрэлт хэрэгцээ их байгааг илтгэж байна.
- Хятад хэлний төгсөгчид хятад хэлний сонгон сургалттай төрийн болон хувийн 30 гаруй ЕБС-д ажиллаж байна. Тэнхимийн төгсөгчдийн нэгдсэн шалгалтын голч оноо 2017-2018 оны хичээлийн жилд 2,74 байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 3,21 болж өссөн.
- Төгсөгчдөөс 2018-2019 оны хичээлийн жилд Зүүн хойд мужийн Багшийн их сургуультай хамтарсан 2+2 төсөл БНХАУ-ын Ханбан байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж эхний ээлжийн 13 оюутан хос дипломтой төгссөн. 2+2 төсөлд 2014-2019 онуудад 178 оюутан хамрагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- 2014-2019 онд нийт 62 төгсөгч, үүнээс мэргэжлээрээ ажиллаж байгаа төгсөгч 27 буюу 43,5%, япон улсад сурч ажиллаж буй 20 /32,3%/ байгаа нь төгсөгчдийн эрэлт хэрэгцээг харуулж хөтөлбөрийн үр дүнгийн чанартай байгааг илтгэж байна.

- Япон хэлний төгсөгчид гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 23,18, 54, “Монгени”, “Шинэ Монгол” бүрэн дунд сургууль ба технологийн коллеж, “Харүмафүжи” болон “Номт Наран” бүрэн дунд сургууль, Япон Монгол төв зэрэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллдаг. Хөтөлбөрийн голч оноо 3,47-оос буурч 2,9 болсон байгааг анхаарч оюутан, багш, хандивлагч, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэгч тал, төгсөгчдийн оролцоог хангасан сэтгэл ханамжийн болон бусад төрлийн судалгааг авч дүгнэлт хийжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчид япон хэлний сургалттай ЕБС-иуд болон бусад сургалтын байгууллагад амжилттай ажиллаж байгаа.

Анхаарах асуудал:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн нэгтгэл ажиглагдаагүй.

Зөвлөмж:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж, эргэх холбоотой ажиллах.

ОРОС:

- 2014-2019 онд орос хэлний багш хөтөлбөрөөр нийт 219 оюутан төгссөнөөс 93 төгсөгч буюу 42,4% нь мэргэжлээрээ ажиллаж байна. Бусад салбарт 31 (14.1%), мөн сурч байгаа 28 (12,7%) тус тус байна.
- Орос хэлний багш мэргэжлээр төгсөгчдийн сүүлийн 5 жилийн голч оноо 2,98-аас буурч 2,72 болсон байна. Энэ нь В- оноо зонхилох хандлагатай байснаа С+, С- оноо зонхилох хандлагатай болсон нь багш нараас үнэлгээний дүндээ дүн шинжилгээ хийж, үнэлгээний тархалтад шинжилгээ хийх, төгсөгчдийн сурах арга, сургалтын явцын чанарыг суралцах хугацаанд нь анхаарч зөв төлөвшүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай болж байна.
- Орос хэлний хөтөлбөрөөр төгсөгчид нийслэл болон орон нутгийн ЕБС-иуд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад ажиллдаг.
- Оюутан, багш хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэгч талын оролцоог хангасан сэтгэл ханамжийн судалгааг хичээлийн жилд 2 удаа авч дүгнэлт хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

СОЛОНГОС:

- Нийт төгсөгчдийн 77,1% нь солонгос хэлний багш, орчуулагчаар ажиллаж мөн үргэлжлүүлэн ахисан түвшинд сурч байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Хамтарсан хөтөлбөрийн анги нээх талаар санаачлагатай ажиллах
- Оюутан солилцооны хөтөлбөрийг бодитоор хэрэгжүүлэх

ХЯТАД:

- Багш, Гадаад хэлний боловсрол багцын хятад хэлний хөтөлбөр анх удаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж байгаа. Магадлан итгэмжлүүлж байсан салбар сургуулиудын туршлага судлан япон хэлний багшийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг анх удаа гаргаж байгаа ажээ.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн чанарыг хүлээн зөвшөөрч байгааг манай улсын хятад хэлний сургалттай 30 гаруй ЕБС-д төгсөгчид ажиллаж байгаа болон нийт төгсөгчдөөс 10 хүн мэргэжлийн дагуу ажиллаж байна.
- Зөвхөн Күнзийн институтийн шугамаар жил бүр хятад хэл судлаж буй 70 гаруй хүмүүстэй ажилладаг.
- Оюутан суралцах БНХАУ-ын их сургуулиудтай байнга холбоотой ажиллаж оюутан солилцох, хамтарсан уулзалт, хичээл зохион байгуулж харилцан хэлэлцэж ирсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

ЯПОН:

- Багш, Гадаад хэлний боловсрол багцын япон хэлний хөтөлбөр анх удаа хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж байгаа. Магадлан итгэмжлүүлж

байсан салбар сургуулиудын туршлага судлан япон хэлний багшийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг анх удаа гаргаж байгаа ажээ.

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн чанарыг хүлээн зөвшөөрч байгааг манай улсын япон хэлний сургалттай сургуулиудад төгсөгчид амжилттай ажиллаж байгаа болон нийт төгсөгчдийн 75,8% нь мэргэжлийн дагуу ажиллаж сурч байгаа баримт нотлож байна.
- Оюутан суралцах хугацаанд япон хэлний багш нарын мэргэжлийн холбоо, Япон Монголын төв, гадаадын их сургуулиудтай байнга холбоотой ажиллаж оюутан солилцох, хамтарсан уулзалт, хичээл зохион байгуулж харилцан хэлэлцэж ирсэн. Төгсөгчдөөс магистратурт 5, докторантурт 1 хүн сурч байна. Энэ нь нийт төгсөгчдийн 9,7 хувь болж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн 75,8% нь мэргэжлийн дагуу ажиллаж сурч байгаа.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн дагуу ажиллаж сурч буй төгсөгчдийн хувь хэмжээг бүрэн хангалттай гэж үзэхэд учир дутагдалтай.
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ тоон үзүүлэлтээр баталгаажаагүй.
- Тоон үзүүлэлт бүхий нийт төгсөгчдийн судалгаа хомс.

Зөвлөмж:

- Мэргэжлийн дагуу ажиллаж сурч буй төгсөгчдийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг тогтмол хийж хэвших.
- Ажил эрхлээгүй болон өөр чиглэлээр ажиллаж буй төгсөгчдийн судалгааг учир шалтгааны хамт тогтмол хийх.

ОРОС:

- Магадлан итгэмжлүүлж байсан сургуулиудын туршлага судлан орос хэлний багшийн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг анх удаа гаргаж байгаа ажээ.
- Хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжлийн чанар нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд төдий байгааг манай улсын орос хэлний сургалттай сургуулиудад

төгсөгчид ажиллаж байгаа болон нийт төгсөгчдийн 55,2% нь мэргэжлийн дагуу ажиллаж сурч байгаа баримт нотлож байна.

- Оюутан суралцах хугацаанд орос хэл уран зохиолын багш нарын мэргэжлийн холбоо, гадаадын их сургуулиудтай байнга холбоотой ажиллаж оюутан солилцох, хамтарсан уулзалт, хичээл зохион байгуулж харилцан хэлэлцэж ирсэн.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй 28 төгсөгч байгаа нь нийт төгсөгчдийн 12,7 хувь болж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжиж ирсэн 68 жилийн хугацаанд ололт амжилтаа бататган хөтөлбөрийг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн байнга сайжруулж, суралцагчдын сурлагын чанар, эзэмших мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ирсний үр дүнд МУБИС-ийн орос хэлний багш мэргэжлийн хөтөлбөр үндэсний хэмжээний шигшмэл хөтөлбөрийн нэг болсон гэж үзэхүйц байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг сурталчлах, хөндлөнгийн үнэлэлт, дүгнэлт авах, цаашид олон улсад үнэлүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авах

Солонгос: 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Хятад хэл: 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Япон хэл: 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Орос хэл: 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Нийтдээ: 7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

МУБИС-ийн “Багш, гадаад хэлний боловсрол” хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Солонгос хэлний багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1 Хөтөлбөрийн төлөвлөлт	3	0	0	
2 Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	
3 Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1		Хэлэхүйн дөрвөн чадварын хичээлийн үндсэн сурах бичиггүй. Хичээлийг багш нарын бэлдсэн гарын авлага дээр үндэслэн явуулдаг.
4 Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5	0	0	
5 Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5	0	0	

6	Багшийн үйл ажиллагаа	3	1		-Хөтөлбөр хариуцагч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээр оюуны өмчийн эрх, инноваци, ашигтай загвар, патент аваагүй. -Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, үнэлгээ хийсэн байдал хангалтгүй.
7	Чанарын үнэлгээ, баталгаа	3	0	0	
Дүгнэлт		Бүрэн хангасан /Бүрэн хангасан 24, Хэсэгчлэн хангасан 2/			

Хятад хэлний багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн	3			
2	Сургалтын үйл	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			

6	Багшийн үйл ажиллагаа	3	1		Хөтөлбөр хариуцагч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээр оюуны өмчийн эрх, инноваци, ашигтай загвар, патент аваагүй. -Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, үнэлгээ хийх.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
Дүгнэлт		Бүрэн хангасан /Бүрэн хангасан 25 /Хэсэгчлэн хангасан 1/			

Япон хэлний багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн Хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1		Үндсэн болон нэмэлт сургалтын хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж хангалттай бус.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			

6	Багшийн үйл ажиллагаа	2	2		Багш нарын эрдэм шинжилгээний ажлын хэмжээ, түвшин, докторын зэрэгтэй багш нарын хувь хангалттай бус.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1		Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь хэмжээ хангалттай бус.
Дүгнэлт		Бүрэн хангасан /Бүрэн хангасан 22, Хэсэгчлэн хангасан 4/			

Орос хэлний багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн Хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3	0	0	
2	Сургалтын үйл ажиллагаа	3	0	0	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3	0	0	
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1	0	-Орос хэлний багш бэлтгэх хөтөлбөрийн удирдлагын тогтвортой байдал нь хос мэргэжлийн элсэлтээс хамаардаг болсон. Мөн ЕБС-д ажиллах багш бэлтгэдэг болон орос хэлний багшийн мэргэжлээр дагнасан төгсөлт хийх нөхцөл байгааг ашиглаагүй.

5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4	1	0	Орос хэлний багшийн мэргэжлээр дагнасан элсэлт авах нөхцөл бүрдүүлэх боломж байгаа болон улсын хэмжээнд орос хэлний багшийн элсэлт тогтмол авч ирсэн ганц их сургууль байгаа давуу талаа бүрэн ашигладаггүй.
6	Багшийн үйл ажиллагаа	4	0	0	
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3	0	0	
Дүгнэлт		Бүрэн хангасан /Бүрэн хангасан 24, Хэсэгчлэн хангасан 2/			

“Солонгос, хятад, япон, орос хэлний багш, гадаад хэлний боловсрол хөтөлбөр”-ийн шинжээчийн үнэлгээний нэгдсэн хүснэгт

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	12	0	0	
2	Сургалтын үйл ажиллагаа	12	0	0	

3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	10	2	0	<p>-Солонгос хэлний багш хөтөлбөр: Хэлэхүйн дөрвөн чадварыг хөгжүүлэх хичээлүүдийн үндсэн сурах бичиг байхгүй. Хичээлийг багш нарын бэлдсэн гарын авлага дээр үндэслэн явуулдаг.</p> <p>- Япон хэлний багшийн хөтөлбөр: Үндсэн болон нэмэлт сургалтын хэрэглэгдэхүүний чанар, хүртээмж хангалттай бус.</p>
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	19	1	0	<p>-Орос хэлний багш хөтөлбөр: Удирдлагын тогтвортой байдал нь хос мэргэжлийн элсэлтээс хамаардаг болсон. Мөн ЕБС-д ажиллах багш бэлтгэдэг болон орос хэлний багшийн мэргэжлээр дагнасан төгсөлт хийх нөхцөл байгааг ашиглаагүй.</p>

5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	19	1	0	<p>-Япон хэлний багш хөтөлбөр: Суралцагчдын шилжилт хөдөлгөөн их.</p> <p>-Орос хэлний багш хөтөлбөр: Уг хөтөлбөрөөр дагнасан элсэлт авах нөхцөл бүрдүүлэх боломж байгаа болон улсын хэмжээнд орос хэлний багшийн элсэлт тогтмол авч ирсэн ганц их сургууль байгаа давуу талаа бүрэн ашиглаагүй.</p>
6	Багшийн үйл ажиллагаа	12	4	0	<p>Солонгос, хятад хэлний багш хөтөлбөр: -Хөтөлбөр хариуцагч багш нар эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлээр оюуны өмчийн эрх, инноваци, ашигтай загвар, патент аваагүй.</p> <p>-Багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн үр нөлөө хичээлийн хөтөлбөрийн чанарт хэрхэн нөлөөлж байгаа талаар багш нарын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, үнэлгээ хийсэн байдал хангалтгүй.</p> <p>Япон хэлний багш хөтөлбөр: Багш нарын эрдэм шинжилгээний ажлын хэмжээ, түвшин, докторын зэрэгтэй багш нарын хувь хангалттай бус.</p>

7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	11	1	0	Япон хэлний багш хөтөлбөр: Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь хэмжээ хангалттай бус.
Дүгнэлт		Бүрэн хангасан /Бүрэн хангасан 95 /Хэсэгчлэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	МУБИС, Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургууль	
Хөтөлбөрийн нэр	Багш, гадаад хэлний боловсрол	
Хөтөлбөрийн индекс	D011409	
Шалгуур Хөтөлбөрийн төлөвлөлт	1.	Орчин үеийн гадаад хэлний боловсролын олон улсын стандарт, үзэл баримтлалыг хичээлийн стандарт, хөтөлбөр, улмаар хичээлийн агуулгад тусгаж ажиллах шаардлагатай.
Шалгуур Сургалтын ажиллагаа	2. үйл	Гадаад хэл заах аргын орчин үеийн арга зүйн талаарх ном, товхимол, зөвлөмжийн хангамжийг сайжруулах, суралцагч төвтэй сургалтын арга зүйг бүх хичээл дээр ашиглахад анхаарах шаардлагатай. Суралцагчийн хэлэхүйн ур чадварын ахиц, хөгжлийг албан ёсны хөндлөнгийн үнэлгээгээр тогтмол үнэлүүлдэг байх.
Шалгуур Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	3.	Үндсэн болон нэмэлт сургалтын хэрэглэгдэхүүний чанар, хүртээмжийг сайжруулах, номын фондыг бүрдүүлэхэд сургуулийн зүгээс тогтмол санхүүжилт олгох тал дээр анхаарах шаардлагатай.
Шалгуур Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.	Хөтөлбөрийн “орц”-оос “гарц” хүртэлх бүх сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгаанд цогц дүн шинжилгээ хийх ажлыг тогтмолжуулан, хөтөлбөрийг сайжруулж ажиллахад анхаарах шаардлагатай.
Шалгуур Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	5.	Суралцагчдын шилжилт хөдөлгөөний учир шалтгаан, элсэгч төгсөгчдийн зохистой харьцаанд анхаарч ажиллах шаардлагатай.

	Оюутны эрдэм шинжилгээний ажлын түвшинг дээшлүүлэн, оролцоог нэмэгдүүлэх.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	Багш нар эрдэм шинжилгээний ажлаа эрчимжүүлэх, түвшингээ ахиулах, эрдмийн зэрэг хамгаалах, сургалт судалгааг уялдуулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай.
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	Төгсөгчдийн ажил эрхлэлт, тэр дундаа мэргэжлийн дагуу ажиллах, дэвшин сурах төгсөгчдийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.
ШААРДЛАГА: /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	Багшлах боловсон хүчнээ нэмж, багш нарын сургалтын цагийн ачааллыг багасгаж, эрдэм шинжилгээ, судалгаа хийх боломж бололцоогоор хангаж, бодлогоор дэмжих.

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн “Багш, гадаад хэлний боловсрол (Орос, Хятад, Япон, Солонгос)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Т.Төрбат

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Г.Томтогтох

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Д.Ундрах

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Н.Мэнд

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Ц.Дэлгэрэхцэцэг

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Сон Ыйминь	Дэд профессор	ШУ доктор	17	1. Солонгос хэлний ярих чадварын хөгжил 1-5 2. Унших чадварын хөгжил 1, 2 3. Найруулга зүйн үндэс 4. Ханз 5. Солонгос хэлний үгзүй 6. Солонгос хэлний өгүүлбэр зүй
2	Ё.Нямхишиг	Багш	Магистр	15	1. Солонгос хэлний хэрэглээний хэл зүй 1-3 2. Солонгос хэлний сургалтын арга зүй 1, 2 3. Зэрэгцүүлсэн хэлзүй 4. Солонгос орон судлал 5. Хэл соёл судлалын үндэс
3	Ч.Дүүрэнжаргал	Багш	Магистр	12	1. Солонгос хэлний бичих чадварын хөгжил 1, 2 2. Сонсох чадварын хөгжил 1, 2 3. Үгийн сангийн хэрэглээ 1, 2 4. Орчуулгын онол, дадлага 5. Дуудах зүй 6. Уран зохиол 7. Орчуулах ур чадварын хөгжил г.м
4	Ш.Цолмон	Тэнхимийн эрхлэгч	Ph.D, дэд профессор	17	Хэл шинжлэлийн удиртгал, Дуудах зүйн үндэс, Ярих, бичих, унших чадварын хөгжил, Орос хэл/сонгон
5	С.Эрдэнэмаам	Профессор	Ph.D, профессор	19	Орчуулгын хэл зүй, Практическая грамматика, Найруулан бичих чадвар, Хэл шинжлэлийн судалгааны арга зүй, Найруулга зүйн үндэс, Багш мэргэжлийн удиртгал, Орос хэл /сонгон/

6	З.Баярчимэг	Дэд профессор	Ph.D, дэд профессор	20	Ярих, бичих чаадварын хөгжил, Өгүүлбэр зүйн үндэс, Хэл суралцагчийг судлах арга зүй, Багш мэргэжлийн удиртгал, Багшлах дадлага
7	Ц.Сэрээнэн	Дэд профессор	Ph.D, дэд профессор	21	Хэл шинжлэлийн удиртгал, Хэрэглээний хэл шинжлэл, Дуудах зүйн үндэс, Ярих, бичих, унших чадварын хөгжил, Хэлний онол, Багш мэргэжлийн удиртгал, Орос хэлний багшлах дадлага, Орос хэл /сонгон/
8	Б.Ургамал	Багш	Ph.D	2	Хэрэглээний хэл зүй, Орос хэлний сургалтын арга зүй, Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй, Багш мэргэжлийн удиртгал, Орос хэлний багшлах дадлага, Орос хэл /сонгон/
9	Б. Анар	Багш	Магистр	3	Хэлний онол, Ярих бичих сонсон, унших чадварын хөгжил, Дуудах зүйн үндэс, Хэрэглээний хэл зүй, Өгүүлбэр зүйн үндэс, Орон судлал, Орос хэлний багшлах дадлага, Орос хэл /сонгон/
10	Н.Баярмаа	Багш	Магистр	14	Бүх мэргэжлийн хичээл
11	Д.Бурмаа	Ахлах багш	Магистр	16	Бүх мэргэжлийн хичээл
12	Б.Ганчулуун	Тэнхимийн эрхлэгч	Доктор	23	Хятад хэлний сургалтын аргазүй, хэлний онол
13	Б.Цэцэгбадам	Багш	Магистр	5	Хятад хэлний сонсох чадварын хөгжил, хятад хэлний ярих чадварын хөгжил
14	Ж.Зулгэрэл	Багш	Магистр	3	Ханз орчуулгын дадлага

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Х.Болор-Эрдэнэ	1	Дотуур байранд амьдардаг. 1-р курсийн төлөөлөл
2	М.Урангоо	2	УБ-т амьдардаг. 2-р курсийн төлөөлөл
3	Г.Анударь	3	УБ-т амьдардаг. 3-р курсийн төлөөлөл
4	Б.Гончигсүм	4	УБ-т амьдардаг. 4-р курсийн төлөөлөл
5	П.Урантогос	ОАХ-1	Хөвсгөл аймгаас элссэн, дотуур байранд
6	Т.Маралмаа	ОАХ-2	Багануураас элссэн
7	Т.Мөнхмаа	ОАХ-3	Дарханаас элссэн, дотуур байранд 1 жил амьдарсан
8	Б.Рэнцэнханд	ОХБ-4	Баянхонгороос элссэн 1 жил дотуур байранд амьдарсан
9	Б.Дуламсүрэн	4	Орон нутгийн
10	Б.Ундрал	3	Орон нутгийн
11	Д.Эрхбилгүүн	2	Орон нутгийн
12	Б. Мөнхжин	4	2+2 хөтөлбөрийн
13	Г.Халиунаа	3	Дотуур байр
14	Г.Сүнжидмаа	2	Орон нутгийн
15	Г. Халиун	1	Орон нутгийн

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Ж.Тунгалаг	52-р сургууль	Гадаад хэлний секцийн ахлагч
2	Г.Цэрмаа	Хүрээ тулга дунд сургууль	Сургалтын менежер
3	Д.Алтансүх	Монгени сургууль	Сургалтын менежер /ажилтай учир уулзалтад ирээгүй/
4	Б.Амаржаргал	ЕБ-ын 20-р сургууль	Сургалтын менежер
5	Ч.Өнөржаргал	ЕБ-ын 48-р сургууль	Сургалтын менежер
6	Н.Отгонбаатар	ЕБ-ын 75-р сургууль	Сургалтын менежер
7	Н.Гүррагчаа	ЕБ-ын 3-р сургууль	Сургалтын менежер
8	Ч.Бат-Амгалан	ЕБ-ын Эрдмийн өргөө цогцолбор сургууль	Сургалтын менежер
9	Э.Цэндсүрэн	Шинэ Монгол технологийн коллеж	Гүйцэтгэх захирал
10	Н.Номин	Номт Наран Япон-Монголын хамтарсан сургууль	Захирал
11	Б.Наранцэцэг	Шинэ Монгол Харүмафүжи дунд сургууль	Сургалтын менежер
12	Б.Урансайхан	ХУИС	Сургалтын албаны дарга

13	С.Баярмаа	Орчлон ОУС	Дунд сургуулийн захирал
14	Л.Болормаа	18 дугаар ЕБС	Хятад хэлний багийн ахлагч

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Б.Халиунаа	2018	Монгени цогцолбор сургууль	Солонгос хэлний багш
2	Б.Дэлгэрмаа	2017	Хүрээ тулга дунд сургууль	Солонгос хэлний багш
3	Хулан	2016	Эдүлайн сургалтын төв	Солонгос хэлний багш
4	Г.Баярнаадам	2014	Идэр дээд сургууль	Сургалтын албаны менежер
5	Пүрэвдорж	2014	Эрдмийн өргөө цогцолбор сургууль	Орос, англи хэлний багш
6	Ө.Баярчимэг	2017	ЕБ-ын “Шинэ үе” сургууль	Орос хэлний багш
7	Г.Оюундарь	2017	ЕБ-ын 84-р сургууль	Орос хэлний багш
8	Б.Эрдэнэбат	2018	ЕБ-ын Логарифм сургууль	Орос хэлний багш
9	С.Амарбаясгалан	2015	Монгол Японы хүний нөөцийн хөгжлийн төв	Япон хэлний багш
10	М.Маралмаа	2016	Номт Наран Япон-Монголын хамтарсан сургууль	Япон хэлний багш
11	Х.Хосцэцэг	2019	Шинэ Монгол Харүмафүжи дунд сургууль	Япон хэлний багш
12	Б.Ундармаа	2014	Солонго FS дунд сургууль	Хятад хэлний багш
13	О.Бямбажаргал	2016	“ЧҮҮ девелопмент” ХХК	Захиргаа, хангамжийн ажилтан
14	Г.Энхзул	2018	БНХАУ-д магистрт сурч буй	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ
НИЙГЭМ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ
СУРГУУЛЬ

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Бага тойруу, Утас: 32 84 50, <http://www.msue.edu.mn>

2020.06.04 № 1145
танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Шинжээчийн багийн дүгнэлтэд
хариу хүргүүлэх тухай

МУБИС-ийн Багш, Гадаад хэлний боловсрол хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэхээр та бүхэнд тус хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан болон хавсралтыг илгээсэн бөгөөд энэ дагуу танай шинжээчид тус сургуульд 2020 оны 05-р сарын 21, 22-ны өдрүүдэд ажиллаж, манай орос, хятад, япон, солонгос хэлний багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөлтэй уулзаж, мөн сургалтын орчин, анги танхим, номын сан зэрэгтэй танилцсан билээ.

Ийнхүү Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлөөс томилсон "Багш, гадаад хэлний боловсрол" /Индекс: D011409/ бакалаврын сургалтын хөтөлбөрийг магадлах шинжээчдийн багийн үнэлгээний тайлантай танилцаж дараах хариуг хүргүүлж байна. Тус шинжээчийн баг ажилласан тайлангаа 2020 оны 06-р сарын 03-нд бидэнд ирүүлсэн бөгөөд тус тайлангийн талаар бидэнд тусгайлан хэлэх санал үгүй бөгөөд шинжээчдийн зөвлөмж, саналыг бүрэн хүлээн зөвшөөрч, хөтөлбөрийн хөгжил, хэрэгжүүлэлтээ анхааран ажиллахыг уламжилж байна.

Бид та бүхэнтэй хамтран ажилласандаа баяртай байгаа бөгөөд цаашид бидний хамтын ажиллагаа улам өргөжинэ гэдэгт итгэлтэй байна.

ЗАХИРАЛ



проф.Ж.БАТБААТАР

Багш, Гадаад хэлний боловсрол хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлангийн багийн ахлагч:

ОРОС ХЭЛ-АРГА ЗҮЙН
ТЭНХИМИЙН ЭРХЛЭГЧ

дэд проф.Ш.ЦОЛМОН

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
..... [Магадлан итгэмжлэх комиссын
хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/